



Шинжээчийн үнэлгээний тайлан

Байгууллагын нэр: МУБИС, Биеийн тамирын сургууль

Хөтөлбөрийн нэр: Багш, биеийн тамирын боловсрол

Индекс: D011410

Шинжээчийн баг:

Ахлагч: П.Лхагвасүрэн

Гишүүд:Р.Гантулга

.....Ч.Зоригтбаатар

Он сар өдөр: 2020.05.19

Агуулга

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Монгол улсын боловсролын их сургууль, Биеийн тамирын сургууль Mongolian State University of Education, School of Physical Education	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Багш, биеийн тамирын боловсрол Teacher, physical education	
Индекс	D011410	
Шинжээчид	Ахлагч: 1. П.Лхагвасүрэн, Боловсролын хүрээлэнгийн захирал Гишүүд: 2. Ч.Зоригтбаатар, Нийслэлийн ерөнхий боловсролын спортын төв сургуулийн захирал 3. Р.Гантулга, МУИС-ийн Биеийн тамирын тэнхимийн ахлах багш	
БМИУЗ-ийн ажлын албаны мэргэжилтэн	Б.Оюунчимэг	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	05/07	Шинжээчид урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	05/14, 15	Сургууль дээр очиж шинжээчид ажиллана.
	05/22	Шинжээчид үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	05/25	Шинжээчдийн үнэлгээний тайланг сургуульд илгээж санал авна.
	05/28	Сургууль үнэлгээний тайлантай танилцаж, тайлбар, нотлох баримтыг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	05/29	Шинжээчид үнэлгээний тайланг эцэслэнэ.

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

МУБИС-ийн Эрхэм зорилго: Хүүхэд бүрийг хөгжүүлэх чадамжтай, бүтээлч багш, боловсролын болон шинжлэх ухааны бусад салбарын мэргэжилтэн бэлтгэн гаргах

Биеийн тамирын сургуулийн эрхэм зорилго: Хувь хүний сонирхол, нийгмийн хэрэгцээ, олон улсын чиг хандлагад нийцсэн багш болон бусад боловсрол эзэмших, судлах, хөгжүүлэх иргэдэд нээлттэй, чанартай үйлчилнэ.

Хөтөлбөрийн зорилго: Биеийн тамир, спортын сургалтын үйл ажиллагааг хүн бүрийн эрүүл мэндийг дэмжих, бие бялдрыг хөгжүүлэх нийгмийн болон хувь хүний хэрэгцээнд тулгуурлан; суралцагч бүрийн хөгжлийн ялгаатай байдал, онцлогийг тооцож, шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулах мэдлэг, чадвар, судалгааны арга барил эзэмшсэн; түүнийгээ амьдрал практикт хэрэглэх хүсэл эрмэлзэлтэй; суралцагч болон өөрийгөө тасралтгүй хөгжүүлэх чадамжтай; үндэсний спортын өв уламжлалаа эрхэмлэдэг биеийн тамирын багш мэргэжилтнийг бэлтгэх

Хөтөлбөрийн түүхэн хөгжлийг он тооллоор нь авч үзэхэд:

- 1955-1956 онд Улсын багшийн институтэд 5 багш, 30 оюутантай биеийн тамирын багш бэлтгэх тэнхим байгуулагдан, 3 жилийн сургалтаар анхны төгсөлт хийж, 27 багшийг бэлтгэсэн байна.

- 1973 оноос эчнээ сургалтын хэлбэрээр биеийн тамирын багшийг бэлтгэж эхэлсэн.
- 1989 оноос спортын дасгалжуулагч, 1996 оноос спортын сэтгүүлч, 2003 оноос спортын аялал жуулчлалын мэргэжилтэн, 2008-2015 онд Биеийн тамир-эрүүл мэндийн багшийг бэлтгэж ирсэн.
- Энэ хугацаанд 5000 гаруй биеийн тамирын багш, 300 гаруй биеийн тамир-эрүүл мэндийн багш, 500 дасгалжуулагч, 200 гаруй спортын сэтгүүлч, 100 гаруй спортын аялал жуулчлалын мэргэжилтэн, 300 гаруй магистр төгсгөжээ.

Биеийн тамирын багш, спортын дасгалжуулагч мэргэжлээр төгсөгчдөөс Монгол улсын хөдөлмөрийн баатар 3, Ардын багш 7, гавьяат багш 5, эрдэмтэн, профессор 40 орчим, спортын гавьяат тамирчин 40 гаруй, гавьяат дасгалжуулагч 32, олимпийн медальтан 8 төрөн гарсан байна. Мөн тус сургуулийн эрдэмтэн багш нар биеийн тамирын дээд ба бага, дунд боловсролын стандарт, 1-12 дугаар ангийн биеийн тамирын сургалтын хөтөлбөр, биеийн тамирын багшийн ном, биеийн тамирын багшийн мэргэжил дээшлүүлэх 11 сургалтын хөтөлбөр зэргийг боловсруулах багийн ахлагч, гишүүнээр тогтмол ажиллаж, эдгээр баримт бичгийг биеийн тамирын багш бэлтгэх сургалтын агуулга, арга зүйтэй уялдуулан хамтран хэрэгжүүлж байгаа нь өөрийн үнэлгээний тайлан болон сургууль дээр очиж ажиллахад баримт бичгээр нотлогдсон. Биеийн тамирын багш бэлтгэх сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрийг Монгол улсын боловсролын шинэчлэлийн чиг хандлагад нийцүүлэн үе шаттай боловсронгуй болгож иржээ.

Тайлант хугацаанд буюу 2018-2019 оны хичээлийн жилд нийт 29 багш ажиллаж байгаагаас доктор багшийн эзлэх хувь 41.3% /12/ байна. Нийт 662 оюутан багш, биеийн тамирын боловсрол хөтөлбөрөөр суралцаж байна.

Ш. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

-Нийгэм, эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд хийсэн дүн шинжилгээ, ажлын төлөвлөгөө, бенчмарк, судалгааны танилцуулга

-Гадаад, дотоодын хөтөлбөрүүдтэй харьцуулсан судалгаа, бенчмарк

-МУБИС болон Биеийн тамирын сургуулийн эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУБИС багш боловсролын хөтөлбөрийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулахдаа Монгол Улсын боловсролын талаарх бодлогын баримт бичгүүдэд үндэслэн төлөвлөж шинэчилсэн байна. Мөн оюутан, төгсөгч, ажил олгогчдыг хамруулан судалгаа авч, хөтөлбөрийн хөгжүүлэлтийг хийсэн туршлага байна. МУБИС-ийн Удирдах зөвлөл 2014 оны 06 сарын 25-ны хурлаараа “МУБИС-ийн бакалаврын сургалтын хөтөлбөр боловсруулахад баримтлах үзэл баримтлал”-ыг баталсан бөгөөд энэхүү үзэл баримтлалын дагуу багш бэлтгэх бакалаврын хөтөлбөр нь дараах 3 зүйлд суурилсан хөтөлбөр болж шинэчлэгдсэн байна.

1. Багшийн итгэл үнэмшил, багшлах ажилд болон хүүхдэд чин сэтгэлээсээ хандах хандлага, төлөвшлийг хөтөлбөрийн зорилт болгож, хувь хүний болон багш

мэргэжилтний үнэт зүйлийн хэм хэмжээг бий болгосноороо үнэт зүйлд суурилсан хөтөлбөр

2. Хөтөлбөрөөр оюутны эзэмших мэдлэг, чадвар, хандлагыг хэмжигдэхүйц үр дүн байдлаар томьёолж, сургалтын агуулга, арга зүй, үнэлгээ, орчин нөхцөлийг хөтөлбөрийн үр дүнг хангахад чиглүүлснээрээ үр дүнд суурилсан хөтөлбөр
3. Суралцах төлөвлөлтөө оюутан өөрөө хийх боломжийг бүрдүүлсэн ба хичээлийн түвшинд бие даан болон хамтран бүтээлчээр суралцах арга зүй, технологийг хэрэгжүүлэх суралцахууд суурилсан хөтөлбөр

“Багш, биеийн тамирын боловсрол” хөтөлбөрийн хүрэх үр дүнг “хүүхэд бүрийг хөгжүүлэх чадамжтай бүтээлч биеийн тамирын багш” бэлтгэх гэж тодорхойлон, сургалтын төлөвлөгөө, арга зүй, орчин хэрэглэгдэхүүн, үнэлгээ, элсэгчдэд тавигдах шаардлага, харилцаа хамтын ажиллагаа зэргийг багтаасан багц хөтөлбөр болгон шинэчилсэн онцлогтой байна.

- Биеийн тамирын багш бэлтгэх чиглэлээр гадаадын 4 их сургууль, дотоодын сургуулийн хөтөлбөрийн бүтэц, дизайн, агуулгыг сургалтын хөтөлбөртэй харьцуулж судалсан байна. Тухайлбал, ХБНГУ-ын Билефелдийн их сургуулийн Биеийн тамирын багш бэлтгэх хөтөлбөр, ОХУ, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Багшийн их сургуулийн биеийн тамирын багш бэлтгэх хөтөлбөрийг тухайн сургуультай 2+2 хөтөлбөр хэрэгжүүлэх, цаашид биеийн тамирын багш бэлтгэх чиглэлээр хамтын ажиллагаагаа өргөжүүлэх төлөвлөгөөтэй байгаа тул тухайн хөтөлбөрт дүн шинжилгээ хийх зайлшгүй шаардлагатай хэмээн үзсэн байна.
- ЕБС-д элсэгчдийн тоо жил ирэх тусам нэмэгдэж байгааг Монгол улсын статистикийн мэдээгээр тогтмол өсөлттэй байгааг харуулсан байна. Хичээл заах биеийн тамирын багшийн эрэлт хэрэгцээ бий болж байгааг баримт нотолгоогоор харуулжээ.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн түвшин тогтоох судалгаанд сонирхогч талуудын саналыг тусгаж байх.
- Хөтөлбөр боловсруулах ажлын хэсэгт оюутан болон хөтөлбөрийг сонирхогч талуудын төлөөллийг оролцуулж байх.

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрөөр төгсөгчийн загвар
- Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлсон баримт бичиг
- Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлох, өөрчлөлтийн талаар олон нийтэд мэдээлсэн баримт материал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУБИС багш боловсролын зорилгыг “Сургалтын үйл ажиллагааг суралцагч бүрийн хөгжлийн ялгаатай байдал, онцлогт үндэслэн шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулах суурь мэдлэг, чадвар эзэмшсэн, түүнийгээ амьдрал, практикт хэрэглэх хүсэл эрмэлзэлтэй, суралцагч болон өөрийгөө байнга хөгжүүлэх сэтгэлгээтэй багш мэргэжилтнийг бэлтгэхэд оршино” хэмээн тодорхойлж мэргэжил тус бүрээр хөтөлбөрийг боловсруулан батлуулж, хэрэгжүүлжээ.
- “Багш, биеийн тамирын боловсрол” хөтөлбөрийн зорилгыг тодорхойлохдоо үр дүнд суурилсан сургалтын хөтөлбөр байх үзэл баримтлалыг үндэс болгосон.
- Биеийн тамир, спортын сургалтад оролцогч хүүхэд залуучуудын эрүүл мэндийг дэмжих, бие бялдрыг хөгжүүлэх чадамжтай, хүсэл эрмэлзэлтэй, бүтээлч биеийн тамирын багшийг бэлтгэх гэсэн хөтөлбөрийн зорилго нь МУБИС-ийн эрхэм зорилготой нягт уялдаж байна. Суралцагчдын хөтөлбөрөөр эзэмших суралцахуйн үр дүнг 1) хувь хүний мэдлэг, чадвар, хандлага, 2) багш

боловсролын мэдлэг, чадвар, хандлага, 3) академик мэдлэг, чадвар, хандлага гэсэн 3 бүлгээр тодорхойлсон байна.

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Баглагдсан хөтөлбөр,
- Хурлын тэмдэглэл
- Сургалтын нэгдсэн төлөвлөгөө, график /матриц/
- Баглагдсан хичээлийн хөтөлбөр

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайдын 2014 оны А/174 тушаал “Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага”-д нийцүүлэн хөтөлбөрөө шинэчлэн боловсруулсан. Багш, биеийн тамирын боловсрол D011410 хөтөлбөр нь энэхүү нийтлэг шаардлагыг бүрэн хангаж байгаа болно.
- Хөтөлбөрийг Биеийн тамирын сургуулийн хөтөлбөрийн дэд хороо, салбар хороогоор хэлэлцэн, улмаар МУБИС-ийн хөтөлбөрийн ерөнхий хороогоор баталгаажуулсан байгааг хуралдааны тэмдэглэлээс харлаа.
- Биеийн тамирын сургуулийн хөтөлбөрийн дэд хороо 2014-2019 онд 18 удаа хуралдаж, “Багш, биеийн тамирын боловсрол” хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилт, сайжруулалттай холбоотой олон асуудлыг хэлэлцэж, нийтдээ 27 санал дэвшүүлж, шийдвэр гаргасан байна. Үүний дагуу хөтөлбөрийн өөрийн үнэлгээний баг төлөвлөгөө гаргаж, үе шаттайгаар үйл ажиллагааг зохион байгуулан хүр дүнд хүрсэн нь давуу талтай байна.
- Багш, биеийн тамирын боловсрол хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөний бүтцийг авч үзэхэд БСШУ-ны сайдын А/174 дугаар тушаалаар батлагдсан бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага /ерөнхий суурь хичээл нийт багц цагийн 30%-иас илүүгүй, мэргэжлийн суурь хичээл 25%-иас илүүгүй, мэргэжлийн хичээл 45%-иас багагүй/-д бүрэн нийцэж байна.

Багцын нэр	Нийт кредит		Үүнээс			
			Заавал судлах		Сонгон судлах	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Ерөнхий суурь	21	16,8	17	13,6	4	3,2
Багш боловсролын суурь	18	14,4	14	11,2	4	3,2
Мэргэжлийн	71	56,8	63	50,4	8	6,4
Багшлах дадлага 1, 2, 3, 4	13	10,4	13	10,4	-	-
Сайн дурын ажил	2	1,6	2	1,6		
Нийт	125	100	109	87,2	16	12,8

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн үр дүнг үнэлэхдээ суралцагч, төгсөгч, ажил олгогчдын оролцоог маш сайн хангаж, танилцуулга уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж байх. Уулзалт хэлэлцүүлгийн үр дүнг хөтөлбөрийн сайжруулалтад ашиглаж хэвших

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- Хичээлийн индекс, хичээлийн суралцахуйн үр дүнгийн матриц
- Удирдлагын мэдээллийн систем дэх сонголтууд
- Сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд хийсэн шинжилгээ
- Дадлагын талаар хамтран ажиллах гэрээ, санамж бичиг, удирдамж, журам, ажлын тайлан, анализ
- Хичээл хоорондын залгамж холбоог харуулсан график /хөтөлбөрийн мод/
- Суралцагчийн цагийн ачаалал тооцсон судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- “Багш, биеийн тамирын боловсрол” хөтөлбөрөөр эзэмших агуулга буюу мэргэжлийн хувьд хүрэх үр дүнгийн 16 мэдлэг, чадвар, хандлагыг суралцагч эзэмшихээр хөтөлбөрт тусгасан нь сургалтын төлөвлөгөөн дэх хичээлүүдээр хэрэгжих боломжтойг өөрийн үнэлгээний тайлангийн хүснэгт 1.5-д үзүүлсэн байна.
- Хөтөлбөрийн агуулга нь хүүхэд бүрийг хөгжүүлэх чадамжтай, бүтээлч биеийн тамирын Багш мэргэжилтнийг бэлтгэхийн тулд орчин үеийн хувь хүний хөгжил ба багш мэргэжилтний ерөнхий болон биеийн тамирын багшийн тусгай мэдлэг, чадварыг эзэмшүүлэхэд чиглэсэн агуулгатай байгаа нь харагдлаа.
- Хөтөлбөрт биеийн тамирын суурь онол, арга зүйн хичээлүүд 6, хүний биеийн бүтэц зүй, спортын анагаах ухааны хичээлүүд 6, спортын тодорхой төрлийн хичээлүүд 12, дадлага 5, хичээлүүдийн залгамж холбоотой ордог.
- МУБИС-д 2014-2015 оны хичээлийн жилээс хөтөлбөрийн шинэчлэл, сургалтын чанарын шинэчлэл хийгдэн кредит системд шилжсэнээр мэдээлэл технологийн шинэ шийдэл бүхий сургалт, удирдлагын үйл ажиллагааг дэмжих, оюутан багш, мэргэжилтнүүдэд хүртээмжтэй сургалт, удирдлага мэдээллийн систем (ULMS)-ийг нэвтрүүлсэн байна. Ингэснээр суралцагч бүр өөрийн суралцах үйл явцыг хариуцан хичээл, өдөр, цаг, багшаа сонгох, төлөвлөлт хийх бүрэн боломжтой болсон давуу талтай байна.
- Багш боловсролын дадлагыг 1-4 курсэд тасралтгүй зохион байгуулж байгаа нь оюутан, багшлах арга зүйд суралцах, хүүхэдтэй ажиллах эв дүйтэй болох, судалгааны арга зүйд суралцах зэрэг олон давуу талыг бүрдүүлжээ.

Зөвлөмж:

- Улирлын төгсгөлрүү оюутнаар олон хичээлийн бие даалтыг хамгаалуулж тэд хэт ачаалал үүсгэдэг үйл явцыг саармагжуулж сургалтын үйл ажиллагаанд жигд, төлөвлөгөөтэй суулгаж өгөх.
- Хөтөлбөрийн судалгааг нарийвчлан хийж, үр дүнг хэлэлцэх замаар бүх хичээлийн стандарт, хөтөлбөрийн агуулга, арга зүй, үнэлгээг чанаржуулан сайжруулах
- Хичээлийн хөтөлбөрийн боловсруулалтыг судлагдахуун бүрээр жигд хийж хэвших

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын аргазүйг хэрэгжүүлэх загвар, заавар, зөвлөмж
- Сургалтын аргазүйд хийсэн анализ, судалгааны баримт материал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- “Багш, биеийн тамирын боловсрол” хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ оюутны оролцоо төвтэй, оюутан бүрийн хөгжих боломж, сургалтын сэтгэл зүйн таатай орчныг бүрдүүлсэн, тэдний бүтээлч үйл ажиллагааг дэмжсэн арга зүй ашиглахыг чухалчилжээ.
- Биеийн тамирын сургуулийн хөтөлбөрийн дэд хорооноос сургалтын арга зүйг сайжруулахад чиглэсэн сургалтуудыг тогтмол үе шаттай зохион байгуулж ирсэн нь үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлантай танилцахад нотлогдсон. Сургалтын үр дүнгээс хөтөлбөрийн арга зүйг шинэчлэхэд хувь нэмэр оруулсан байна.
- Тус сургуулийн хөтөлбөрийн алба, дэд хорооноос “Биеийн тамирын багш бэлтгэх сургалтын бүтээлч аргууд” гарын авлагыг 2019 онд боловсруулан хэвлэж, хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ ашиглаж байна.

Анхаарах асуудал:

- Сургалтын арга зүйн судалгааг хийж, хөтөлбөрийг хөгжүүлэхэд анхаарах

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтад ашиглаж буй үнэлгээний аргазүйн судалгаа. /Блум таксономи, Рубрик арга г.м/
- Хичээл нэг бүрийн үнэлгээнд хийсэн дүн шинжилгээ, анализ /Шалгалтын хэлбэр, асуулт даалгавар, сорилын санд хийсэн шинжилгээ/
- Явцын болон төгсөлтийн шалгалтын журам
- Суралцагчийн сурлагын амжилт, ахицын талаарх статистик мэдээлэл, боловсруулалт, дүгнэлт /голч дүн, хичээлд унасан оюутны тоо, сурлагын амжилт, чанар гэх мэт/

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУБИС-ийн хөтөлбөрийн ерөнхий хорооноос “Үнэлгээний даалгавар боловсруулах шаардлага, зөвлөмж”-ийг баталж, багш бүр өөрийн хичээлийн үнэлгээний даалгаврыг танин мэдэхүйн түвшин тус бүрээр, тухайн хичээлээр оюутанд эзэмшүүлэх мэдлэг, чадвар, хандлага буюу хичээлийн үр дүнг (CLO)-г үнэлэх байдлаар боловсруулж, үнэлгээний сан бүрдүүлжээ.
- 2017-2018 оны хичээлийн жилд мэргэжлийн 22 хичээлийн 701 даалгавар, 2018-2019 оны хичээлийн жилд 24 хичээлийн 1039 даалгаварыг баталгаажуулан, тестийн найдвартай чанарыг туршиж, сайжруулсан.
- 2019-2020 оны хичээлийн жилээс гарааны үнэлгээ хийж эхэлсэн ба нийт 50 даалгавар бүхий 3 хувилбарт гарааны үнэлгээний нэгдсэн сан бий болгож, 100 гаруй оюутанд гарааны үнэлгээ хийгээд байна.

Анхаарах асуудал:

- Сурлагын ахиц амжилтад дүн шинжилгээ хийж, үр дүнг нь хөтөлбөрийг сайжруулахад анхаарах

Зөвлөмж:

- Суралцагчийн явцын болон эцсийн үнэлгээнд тогтмол шинжилгээ хийж, хөтөлбөрийн шинэчлэлд ашиглаж байх

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан, түүнд хавсаргасан баримт бичгүүд
- Сургуулийн сургалтын анги танхим, спортын судалгааны лаборатори, номын сан, уншлагын танхим, лекцийн танхим, спорт тоглоомын заал, хөнгөн атлетикийн заал, жудо (чөлөөт бөх, үндэсний бөх) бөхийн заал, спортын гимнастик, аэробик, бодибилдингийн заал, физик эмчилгээний өрөөтэй танилцсан.
- Хичээлийн байр, сургалтын орчны хүрэлцээ, техник хэрэгслийн хангамж, ашиглалтын талаарх суралцагчдын сэтгэл ханамжийн судалгаа
- Багш, оюутнуудтай хийсэн уулзалт, ярилцлага

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2015-2019 оны хичээлийн жилд анги танхим, лаборатори, багшийн ажиллах орчныг стандартад нийцүүлэн сайжруулах чиглэлээр олон ажил хийсэн байна. Тухайлбал: сургалтын орчны үзлэг, судалгаанд үндэслэн спортын 106, 107 тоот заалны хана, шал, агааржуулалт, гэрэлтүүлэг; бөхийн 108 тоот заалны хана, тааз, цонх, гэрэтүүлэг; гимнастикийн 109, 110 тоот заалны хана, тааз, шал, агааржуулалт; бялдаржуулалтын заалыг шилжүүлэн тохижуулах; лекц, семинарын бүх танхимд урсгал засваруудыг жил бүр төлөвлөж гүйцэтгэж, сургалтын орчин, сургалтын хэрэглэгдэхүүн болон бусад зардалд 103.592.981 төгрөгийг зарцуулжээ. Төв аймгийн Батсүмбэр сумын Шатан хэмээх газарт явган аяллын болон цанын хээрийн дадлага хичээлийн баазыг байгуулан, дадлагыг явуулдаг байна.
- Биеийн тамирын сургуульд өнөөгийн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй оюутан байхгүй байгаа боловч 2017-2018 оны хичээлийн жилд тусгай хэрэгцээтэй оюутанд зориулан сургуулийн үүдний орох, гарах хэсэгт хаалганы босгонд пандусыг шинээр хийсэн. Багш бүр компьютерээр хангагдсан.
- 2011 онд сүлжээний хурд дотооддоо 100 мега байт, гадагшаа 20 мега байт урсгалтай байсан бол 2014 оноос өргөтгөл хийснээр дотооддоо 1 гига байт, гадагшаа 100 мега байт болж өндөр хурдны сүлжээтэй болсон төдийгүй бие даасан серверүүд дээр цахим болон онлайн үйл ажиллагааг явуулж байна. Хичээлийн болон оюутны байр өндөр хурдны шилэн кабелиар холбогдсон ба багш, оюутан бүр өөрийн ID кодоо ашиглан үнэ төлбөргүй утасгүй интернэтийн сүлжээнд холбогдон, цахим орчинд ажиллах, бие даан болон хамтран суралцах боломжоор хангагдсан байна. Мөн нэг цэгийн үйлчилгээ, номын сан, оюутны өөрөө үйлчлэх танхим зэрэгт интернэт болон цахилгааны эх үүсвэрийг ашиглаж, оюутан нь дүнгийн жагсаалт, тодорхойлолт зэргийг ТҮЦ машинаас авах боломжтой болсон давуу талууд байна.

- МУБИС нь 2014 оноос хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, мэдээллийн системийг боловсруулан, мэдээллийн санг бүрдүүлэн, бүртгэл тооцоог цахимжуулан, сургалтын алба (sa.surgalt.mn), багшийн вэб (teacherweb.surgalt.mn), оюутны вэб (studentweb.surgalt.mn) гэсэн дэд системүүдээс бүрдүүлж, хэрэгжүүлж байна.

Зөвлөмж:

- Суралцагчдын бие даан ажиллах орчинг сайжруулах

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын хэрэглэгдэхүүн, нөөцийн жагсаалт, хүртээмж, ашиглалт, сэтгэл ханамжийн судалгаа
- Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмж
- E-контент түвшинд боловсруулсан сургалтын материал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Дэлхийн 50 гаруй оронд мэдээллийг хүргэдэг, 170.000 гаруй номын сантай, сайн чанарын бүх төрлийн мэдээллийг агуулсан (ном, сэтгүүл, CD, тэмдэглэл, их хурлын илтгэл, мэдээллийн товхимолтой), ойролцоогоор жилд 2200 сэтгүүл 8400 ном цахим хэлбэрээр, тухайлбал шинжлэх ухаан, технологи, анагаах ухаан зэрэг салбараар нэмэгдэж байдаг “SPRINGER” цахим санг МУБИС-ийн ашиглах эрхийн лицензтэйгээр багш бүр ашиглах таатай орчин бүрдсэн.
- Сургалтад дараах программ хангамжийг хэрэглэж байна.

№	Программын нэр	Зориулалт
1.	Snagit	Компьютерын дэлгэц дэх объектыг хэсэгчлэн болон бүхлээр нь хөдөлгөөнтэйгээр авч, түүнийгээ засварлахад зориулагдсан.
2.	Ulead video studio	Бүх төрлийн видео файльтай ажиллахад зориулагдсан.
3.	Sound Forge	Дууны бүх төрлийн файльтай ажиллахад зориулагдсан.
4.	Macromedia Flash	Вэб сайт видео, мультмедиа, онлайн сургалт, сурталчилгаа, тоглоом, интерфейс зэрэгт ашигладаг.
5.	Lecture Maker	Мультимедиа агуулгатай хичээлийн материал бэлтгэхэд зориулагдсан.
6.	Articulate Quizmaker	Цахим тест болон асуулт бэлтгэхэд ашигладаг.
7.	AutoRun Design Specialty	CD, DVD дээр материал бичихэд зориулагдсан.
8.	Netsupport Shool Tutor	Онлайнаар сургалт явуулахад ашигладаг бөгөөд багш, оюутнууд хоорондоо эргэх холбоотой ажиллах
9.	Dr.Web.agent 11.0	Лицензтэй вирусын программ
10	Dartfish	Спортын дасгалын техникийг задлан шинжилгээ хийхэд зориулагдсан.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгслийн судалгааг жил бүр гаргаж байх

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Үндсэн сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний сэтгүүлийн жагсаалт, сэтгэл ханамжийн судалгаа.

- Мэргэжлийн ном, сурах бичгийн баяжилт, шинэчлэлтийн судалгаа

- Цахим мэдээллийн сан, нээлттэй эх үүсвэрийн ашиглалтын судалгаа.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Онцлог зүйл/Туршлага:**

- Одоогийн байдлаар МУБИС-ийн номын санд биеийн тамир, спортын чиглэлээр монгол ном 3950 ширхэг, орос ном 2245 ширхэг байдаг бөгөөд Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн орчин үеийн мэргэжлийн сэтгүүлүүдийг улирал тутам захиалан, багш, оюутнууд ашиглаж байна. Тухайлбал: “Физическая культура: воспитание и образования”, “Теория и практика физкультуры”, “Физическая культура в школе”, зэрэг сэтгүүлийг сүүлийн 3 жил хэвлэл захиалгад оруулсан болно.
- Сүүлийн 5 жилийн хугацаанд ном сурах бичигт 2014 онд 1.629.500₮, 2015 онд 350.0₮, 2016 онд 450.0₮, 2017 835.0₮, 2018 онд 1.280.000₮ төгрөг зарцуулсан байна.
- “Багш, биеийн тамирын боловсрол” хөтөлбөрийн заавал судлах 24 хичээлийн 12 хичээл нь сурах бичигтэй байна. Нийт 20 сурах бичиг ашиглаж байгаагаас 9 хичээлийн сурах бичгийг Биеийн тамирын сургуулийн багш нар зохиосон.
- Хөтөлбөрийн агуулгын тодорхой хэсгүүдээр багш бүр гарын авлага, зөвлөмж боловсруулан оюутанд хэрэглүүлж байгаагаас 2014-2019 онд нийт 20 гаруйг зохиож, заримыг гадаад хэлнээс орчуулан хэвлүүлсэн сайн туршлага байна.
- МУБИС-ийн захиралын А/239 тоот тушаалаар батлагдсан “Сурах бичиг, гарын авлагад тавигдах шаардлага”-ыг үндэслэн сургууль, тэнхимээс хөтөлбөр дагасан сурах бичиг, гарын авлагыг шинээр боловсруулах төлөвлөгөө гарган ажиллаж байна.

2014-2019 оны хичээлийн жилд ном сурах бичгийн баяжилт

№	Он	Сурах бичиг	Зохиогчийн нэр
1.	2014	Сагсан бөмбөгийн үндсэн дасгал сургуулилт, хамгаалалт	Б.Дамба
		Гимнастик сурах бичиг	Ж.Баасандамба
2.	2015	Волейболын багш, дасгалжуулагчийн сурах бичиг	Р.Тамир
3.	2016	Хөнгөн атлетик	Л.Уртнасан нар
		Спортын анагаах ухаан	Д.Энхжин
		Эрүүлжүүлэх аэробикийн онол, заах арга зүй	Б.Бат-Отгон
4.	2017	Биеийн тамирын онолын үндэс	Л.Уртнасан, Б.Нармандах
5.	2018	Өсвөрийн тамирчдын дасгалжуулалтыг төлөвлөх арга зүй	И.Жамъяндагва
6.	2014-2019	Нийт	8

- Биеийн тамирын сургууль 2014-2019 онд нийт 8 сурах бичиг гарган ажиллажээ. Цаашид сургалтын арга зүй, физиологи, дасгалжуулалтын онол, спорт тоглоомын төрлүүдээр бурах бичиг хэвлүүлэхэд бэлэн болсон байна.
- 1898 м.кв талбай бүхий 640 суудал, 183,631 ширхэг мэдээллийн сантай, чөлөөт сонголтын үйлчилгээгээр 21 номын санч, мэдээллийн ажилтан ажилладаг энэхүү номын сан нь 2016 оны 05-р сарын 14-нд сургалт, судалгаа, инновацийн төв болон өргөжин, үйл ажиллагаагаа явуулж эхлээд байгаа бөгөөд номын сангийн төрөлжсөн судалгааны

танхим, гэрээр ном олгох танхим зэргийг сургуулийн дотоод нөөц бололцоог ашиглан тохижуулж, орчин үеийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах, үйлчилгээний түргэн шуурхай таатай орчинг бүрдүүлэн ажиллаж байна.

- Уншигчдын эрэлт хэрэгцээнд үндэслэн эрдэм шинжилгээ судалгааны бүтээл, эрэлт ихтэй цөөн хувьтай ном сурах бичиг унших, цахим ном унших, хайх зориулалт бүхий 30 ширхэг тавлетийг суурилуулж, нийт 287 ном сурах бичиг, судалгааны материалыг цахим хэлбэрт шилжүүлсэн. Үүнд: SPIE цахим номын сан <http://spiedigitallibrary.org/>, JStor Цахим номын сан <http://www.jstor.org/>, SPRINGER <http://link.springer.com/>, Annual Reviews – Жилийн тоймууд <http://www.annualreviews.org/>, онлайн мэдээллийн сан <http://elibrary.imf.org/>, Вангийн нийгэмлэг <http://www.royalsocietypublishing.org/journals>, University of Chicago Press – Чикагогийн Их Сургуулийн хэвлэл <http://www.journals.uchicago.edu>. Сургуулийн 7700 нэр төрлийн 26000 ширхэг номын е-каталогийг бүрдүүлж, номын сангийн үйлчилгээ цахим хэлбэрт шилжсэн байна.
- Номын сангийн хангамж, суралцаж буй чиглэлээр ном сурах бичиг, ЭШ-ний судалгааны материал хүрэлцээтэй байдаг эсэхийг тодруулахад нийт судалгаанд оролцогчдын 10% маш сайн гэж үнэлсэн. Номын сангийн суудлын хүрэлцээ хангамж, тохижилтыг 58% маш сайн, 34% дунд зэрэг, 8% маш муу гэж үнэлсэн байна.

Анхаарах асуудал:

- Хичээлийн үндсэн сурах бичгийн тоо цөөн тул хүрэлцээний асуудал гарч ирсэн байна.

Зөвлөмж:

- Мэргэжлийн шинэ ном сурах бичиг, бүтээлийн тоог нэмэгдүүлэх, мэргэжлийн тэнхимийн багш нар хамтран сурах бичиг зохиох тал дээр анхаарч ажиллах

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцаж таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн хороо, профессорын баг, тэнхимийн хурлын шийдвэр, тэмдэглэл
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой эрхзүйн баримт бичиг, эрхзүйн баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ
- Хөтөлбөрт ирсэн санал гомдол, шийдвэрлэлтийн тайлан
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн урт, дунд, богино хугацааны тайлан, төлөвлөгөө.
- Тайлан төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ
- Сургалтын удирдлага, мэдээллийн системийн ашиглалт, хяналт, ил тод байдалд хийсэн дүн шинжилгээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУБИС-ийн захирлын 2014 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн А/165 тоот тушаалыг үндэслэн биеийн тамирын сургуулийн хөтөлбөрийн дэд ба салбар хороог байгуулан хичээлийн хөтөлбөрүүдийг хэлэлцэж батлах, хэрэгжилтэд хяналт тавих, үнэлэх, санал авах, өөрчлөлт оруулах, сургалтын хөтөлбөртэй холбоотой бодлого шийдвэрийг хөтөлбөрт тусган

хэрэгжүүлэх үйл ажиллагааг ил тод нээлттэйгээр хэлэлцэж үнэлгээ, дүгнэлт өгч ажилласан байна. Үүнд:

- Багш, биеийн тамирын боловсролын бакалаврын сургалтын хөтөлбөр, стандарт боловсруулах багийн хүрээнд 6 удаагийн сургалт, хэлэлцүүлгийг үе шаттай зохион байгуулан хөтөлбөрийн сургалтын үр дүн, академик мэдлэг, чадвар, хандлага, биеийн тамирын багшийн мэдлэг, чадварыг холбоо хамааралтай боловсруулах ажлын талаар хэлэлцэж санал бодлоо нэгтгэж ажилласан.
- Багш биеийн тамирын боловсролын бакалаврын сургалтын хөтөлбөр дэх хичээлийн хөтөлбөр боловсруулах ажлыг 10 удаагийн сургалт семинар, хэлэлцүүлгээр олгож ажилласан.
- МУБИС 2016-2017 оны хичээлийн жилд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах үүднээс МУБИС-ийн дүрмийн 4.4.1, 4.8.1, МУБИС-ийн “Багшийн ажиллах журам”-ын 1.3.1, 2.1.7, 4.4.4, 5.1, ”Санхүүгийн журам”-ын 6.7.26-р заалтыг тус тус үндэслэн “100 сайн хичээлийн аян”-ыг зохион байгуулсан бөгөөд хөтөлбөрийн багш нар амжилттай оролцсон байна. Тухайн аяны зорилго нь сургалтын шинэчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн агуулга, арга зүй, технологи, үнэлгээ бүхий хичээлийн сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, багшийн ур чадвар, хөгжлийг дэмжих зорилготой байна.
- 2014-2015 оны хичээлийн жилээс хөтөлбөрийн удирдлагад мэдээллийн технологийг нэвтрүүлсэн ба оюутан хөтөлбөрийн талаарх үнэлгээг цахимаар өгч үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэгч багшийн мэдээллийн санд шууд холбогддог учраас тухайн багш багшлахуй хийгээд хөтөлбөрөө хэрхэн сайжруулах талаар өөрийн төлөвлөгөөг боловсруулан ажиллах боломжийг бүрдүүлж чадсан. Ингэснээр багш өөрийн үйл ажиллагаа шүүн тунгаах, сайжруулах боломжтой болсон байна.
- 2016-2017 оны хичээлийн жилээс “Athlete Career” хөтөлбөрийг спортын өндөр зэрэглэлийн тамирчныг элсүүлэн сургах сургалтын төлөвлөгөөг шинээр боловсруулан, 2018-2019 оны хичээлийн жилээс “Биеийн тамирын багш, арга зүйч” мэргэжлийн шинэ сургалтын хөтөлбөрийн нээн, элсэлт авч сургалтын үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна.
- 2014-2015 оны хичээлийн жилээс эхлэн цахимаар оюутан судалсан хичээлийн дүнг үзэхдээ тухайн хичээлийг заасан багшийн талаар сэтгэл ханамжийн судалгааг өгч санал, гомдол, хүсэлтээ илэрхийлэх боломжтой болсон.

Анхаарах асуудал:

- Улирлын төгсгөлд авдаг сэтгэл ханамжийн судалгаанд оюутнууд ач холбогдол өгч, хариуцлагатай хандах нөхцөлийг бүрдүүлэх талаас анхаарах

Зөвлөмж:

- УМС-ээр дамжуулан оюутнуудаас сургалт, багш, сургуулийн үйл ажиллагаатай холбоотой судалгаа, санал хүсэлт авч буй асуулгын оновчтой байдал, тоо хэмжээг эргэн харж, судалгаа авахдаа оюутнуудын өгч буй үнэлгээний бодит байдал, хандлага, асуулга бөглөхдөө хэр үнэн бодитой дүгнэж байгаа эсэхэд анхаарал хандуулж, нягтлах, шалгах, хяналт тавих

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Хэрэгжүүлж буй хамтарсан төсөл, хөтөлбөрүүдийн гэрээ, хэлцэл, ажлын тайлан
- Багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдагсдын тоон судалгаа, дүрэм журам
- Нийгэмд үзүүлсэн үйлчилгээний хэлбэр, хамрагдагсдын тоо, үр дүн, ажлын тайлан, дүгнэлт /багш, суралцагчдын зүгээс/
- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааны баримт материал
- Төгсөгчдийг давтан сургалтад хамруулсан талаарх тоон мэдээлэл

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУБИС-ийн Биеийн тамирын сургууль гадаадын 8, дотоодын 18 болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо, нийслэлийн ЕБС-ийн 74 сургуультай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар болон танилцах, судлах, туршин заах ба багшлах дадлагуудыг хамтран зохион байгуулдаг байна.
- Хөл бөмбөг, гимнастик, бодибилдинг, волейбол, сагсан бөмбөг, жиу-жицу, чөлөөт бөх, хөнгөн атлетикийн холбоодтой бакалаврын хөтөлбөрийг хэрэгжүүлэх магистрын хөтөлбөрт хамруулах үйл ажиллагааг хамтран зохион байгуулдаг байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрт хамрагдаж буй багш, оюутнуудын хүрээнд гадаад харилцаагаа өргөжүүлэх

Зөвлөмж:

- Ижил хөтөлбөрөөр мэргэжилтэн бэлтгэдэг дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагуудын эрдэмтэн судлаач, багш нартай хамтарсан төсөл, хөтөлбөр, судалгаа шинжилгээний ажлыг нэмэгдүүлэх.

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн жилийн төсөв, зарцуулалтын тайлан
- Нэг суралцагчид ноогдох өртөг зардлын тооцоо
- Сургалтын төлбөрөөс хөтөлбөрт зарцуулагддаг хувь хэмжээ, үр дүнгийн судалгаа
- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсөв, төсвийн зарцуулалт
- Төр, хувийн хэвшлийн дэмжлэг, санхүү түүний зарцуулалтын тайлан

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 1,248,695,000 байсан бол 2019 оны батлагдсан төсөв 1,407,834,000 болж өссөн нь кредитийн төлбөр нэмэгдсэнтэй холбоотой байна. *БТС-ийн орлого зарлагын баланс*

№	Хичээлийн жил	Санхүүгийн үр дүнгийн тайланд туссан орлогын нийт дүн	Санхүүгийн үр дүнгийн тайланд туссан зардлын нийт дүн
1	2014-2015	2,198,448,000	2,235,871,738
2	2015-2016	2,494,441,423	2,500,632,336
3	2016-2017	1,528,530,622/ 481,793,569	1,562,286,999/ 440,254,340
4	2017-2018	1,248,695,000	1,235,353,918
5	2018-2019	1,407,834,000	955,291,068
Нийт			

Анхаарах асуудал:

- Сургалтын төлбөрөөс санхүүгийн бусад эх үүсвэрийг эрэлхийлж, нэмэлт хөтөлбөрөөр орлого оруулдаг болох.

Зөвлөмж:

- Нэг суралцагчид ногдож буй зардал яг юунд зарцуулагддагийг нээлттэй харуулдаг байх

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Тандан судалгаа, дүгнэлт, холбогдох материал
- Хийсэн ажил, арга хэмжээ, тайлан, баримт

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2019 оноос элсэлтийн маркетингийн ажлын хэсгийг байгуулан төлөвлөгөө боловсруулж сургуулийн захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэн баталж, хөтөлбөрийн сурталчилгаа, маркетингийн идэвхжүүлэлтийг ашиглан ажилласан байна. Тухайлбал, Эцэг, эх, ЕБС-ийн төгсөгч нарт зориулан сургуулийн болон хөтөлбөрүүдийн давуу тал, онцлогийг харуулсан хэвлэмэл хуудсыг ангарсан жил сайжруулан боловсруулж 1000 ширхэгийг хэвлүүлэн “Боловсролын үзэсгэлэн яармаг”, уулзалт арга хэмжээ, спортын тэмцээн уралдаан, хөтөлбөр сурталчлах өдөрлөг зэрэг үйл ажиллагааны үеэр 800 гаруй хэвлэмэл хуудас тарааж сурталчилгаа хийсэн байна.
- Нийгмийн сүлжээний Facebook платформ-д ашиглаж буй пэйж хуудас, албан ёсны групп зэрэг цахим сувгуудаар сургалтын үйл ажиллагаа болон хөтөлбөрүүдийн онцлог, давуу талыг нийтэд түгээж сурталчлахын зэрэгцээ, пэйж хуудсны чатаар сонирхсон хүн бүхэнд байнгын мэдээллийг хүргэж үйлчилдэг. Дээрх сувгуудаар 600 гаруй зураг, видео контент мэдээлэл хүргэж, 60 орчим хүний сонирхсон асуултад файсбүүк чатаар хариулт өгсөн байна.
- Жил бүрийн 9-р сарын 2-р долоо хоногт шинээр элссэн оюутнуудад мэргэжлийн баримжаа олгох, оюутнуудын чөлөөт цагийг зөв боловсон үр бүтээлтэй өнгөрүүлэх, тэдний идэвхжүүлэх зорилгоор 2018-2019, 2019-2020 оны хичээлийн жилд сагсан бөмбөг, волейболын төрлөөр шинээр элсэгчдийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж ирсэн байна.



Анхаарах асуудал:

- Төгсөгчдөөс үргэлжлүүлэн суралцаж байгаа хүний тоо харьцангуй цөөн байгаад анхаарах
- Төгсөгчдөөс ахисан түвшинд гадаадын их дээд сургуульд суралцаж байгаа талаарх тандалт судалгаа, мэдээлэлд дүгнэлт хийж сурталчлах.

Зөвлөмж:

- Төгсөгчдийг давтан сургах хэрэгцээ шаардлагыг судалж, төлөвлөгөө боловсруулан давтан сургах

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

-Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжээс гаргасан сонин, сэтгүүл, ном товхимол гарын авлага, цахим мэдээллийн жагсаалт

-Вебсайтын мэдээллийн иж бүрэн байдал, тогтмол ажиллагаа

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУБИС-ийн веб сайт 2012 оноос www.msue.edu.mn албан ёсны веб сайт нь бүтэц, агуулгын хувьд бидний тухай, шилэн данс, захиргаа, гадаад харилцаа, сургалт, элсэлт, оюутан, номын сан, мэдээлэл гэсэн үндсэн 9 цэстэй бүрэлдэхүүн сургууль, эрдэн шинжилгээ, инноваци, үйлдвэр, үлдвэрчний эвлэл, ахмадын хороо, ажлын байр гэсэн 6 туслах цэс, онцлох мэдээ, хэзээ, хаана юу, төгсөгчдийн холбоо, төгсөлт, элсэлт, багш боловсролын шинэчлэл, инноваци, урсдаг зар гэсэн бүтэцтэй. Эдгээр үндсэн болон туслах цэсүүд нь мэдээллүүдийг ангилж дэлгэрүүлэн 90 орчим дэд линкээр мэдээллийг ангилан хүргэж байна. Мэдээллийн агуулга, багтаамж өдрөөс өдөрт баяжигдан 7 хоногт дунджаар 20-30 мэдээ, мэдээлэл веб сайтад тавигдаж байгаа нь тус сайтад хандах хандалтын тоо өдрөөс өдөрт нэмэгдэх гол үндсэн нөхцөл болж байгаа хэмээн үзэж байна.
- МУБИС-ийн шинэчлэл, сургалтын болон удирдлага мэдээллийн олон онлайн системүүдийг хэрэгжүүлж эхэлсэнтэй холбогдуулан МУБИС-ийн веб сайтыг агуулга, бүтэцэд дахин шинэчлэл хийх хэрэгцээ шаардлагын дагуу Захирлын тушаалаар батлагдсан ажлын комисс өргөн бүрэлдэхүүнтэйгээр ажиллан шинэ сайтаар хөгжүүлсэн. 2016 онд МУБИС-ийн www.msue.edu.mn домэйн нэрийг www.mnue.mn болгон өөрчилсөн бөгөөд веб сайт нь хэрэглэгч өөрт хэрэгтэй мэдээллээ үзэхэд хялбар интерфестэй, агуулга болон үйл ажиллагааны ил тод байдлыг бүрэн хангаж чадахаар болсон байна. Үүний үр дүнд веб сайтад нийтлэгдсэн мэдээллийг нэг өдрийн нийт хандалтын дундаж тоо 2494 болж өссөн байгааг сайтнаас танилцлаа.

Анхаарах асуудал:

- БТС-ийн контентын агуулга, дизайн анхаарах, цахим талбараа тогтмол ажиллагаатай болгож идэвхжүүлэх сурталчлах, админ, модираторуудыг ажлын үүрэг оролцоог тодорхой болгох

Зөвлөмж:

- ББТБ хөтөлбөрт зориулсан пэйж хуудастай болох

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Элсэлтийн бодлого, дүрэм журам
- Элсэгчдийн ЕШ-ын дундаж оноо, хүсэлт гаргасан болон элссэн суралцагчдын харьцаа
- Шинэ суралцагчдад зориулсан мэдээлэл, гарын авлага
- Гадаад оюутны элсэлтийн тоо

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрт тавигдах шаардлагын дагуу баримт бичгийг боловсруулжээ. Элсэлтийн бодлогыг тус хөтөлбөрийн шинэчлэлтэй уялдуулсан байна. Элсэлтийн ерөнхий шалгалт болон спортын ур чадвар, түүнтэй дүйцүүлэх шалгалтын дүнг тооцож болох хүчинтэй хугацааны дотор элсүүлнэ. МУБИС-д элсэхдээ Боловсрол, Шинжлэх ухааны сайдын 2019 оны А/79 тоот тушаалаар баталсан “Оюутан элсүүлэх журам” болон МУБИС-д элсүүлэх журмыг баримталж байна.
- Түүнчлэн сургуулийн онцлогоос шалтгаалан спортын өндөр зэрэг цолтой, уралдаан тэмцээнд сайн амжилт үзүүлсэн багшлах эв дүй, авъяас, чадвар, хүсэл сонирхолтой элсэгчийг Биеийн тамирын сургуульд урилгаар суралцах эрхийн бичиг олгож, элсэлтийн шалгалтаас чөлөөлөн
 - Монгол хэлний хичээлээр ЭЕШ өгч зохих оноог авсан
 - Насанд хүрэгчдийн УАШТ-нээс медаль хүртсэн
 - Өсвөр үеийн УАШТ-нд түрүүлсэн
 - Олон улсын түвшний тэмцээнээс медаль хүртсэн зэрэг болзлыг хангасан бол элсүүлдэг. Багш, биеийн тамирын боловсрол хөтөлбөрт урилгаар суралцагчид БСШУСЯ-ны гаргасан тушаал шийдвэрийг хангадаг тул яамны мэдээллийн системд тогтмол бүртгүүлж ирсэн байна. Сүүлийн 5 хичээлийн жилд 10 орчим оюутныг урилгаар элсүүлсэн байна.
- Гадаадын иргэнийг оюутнаар элсүүлэн суралцуулах үйл ажиллагааг Монгол улсын дээд боловсролын тухай хууль, БСШУС-ын сайдын 2001 оны 113 дугаар тушаалаар батлагдсан Монгол улсын дээд боловсролын байгууллагад гадаадын иргэдийг суралцуулах журам, МУБИС-ийн сургалтын журамд нийцүүлэн зохион байгуулдаг.
- БТС-ийн Багш, биеийн тамирын боловсрол хөтөлбөрт элсэгчдийн тоо сүүлийн жилүүдэд тогтмол өссөн үзүүлэлттэй байна. Үүнд:
 - Элсэлтийн ерөнхий шалгалтад (ЭЕШ) монгол хэлний хичээлээр 450 (2014 онд), 480 (2018 оноос), оноо авсан байх
 - Мэргэжлийн ур чадварын шалгалтанд 480-аас дээш оноо авсан байх ёстой.

Багш, биеийн тамирын боловсрол хөтөлбөрт элсэгчдийн ЕШ-ийн оноог авч үзвэл:

№	Хичээлийн жил	Элсэгчдийн тоо	Босго оноо	ЭЕШ-ын дундаж оноо		
				дээд	доод	дундаж
1	2014-2015	196	450	631	400	498
2	2015-2016	147	450	607	388	463
3	2016-2017	197	450	740	405	512
4	2017-2018	213	450	708	400	499
5	2018-2019	226	480	688	410	496
Нийт		979				493

Тус хөтөлбөрөөр элсэгчдийн элсэлтийн шалгалтын дээд, доод, дундаж оноог ЭЕШ-ын оноо ба ур чадварын шалгалтын онооны нийлбэрээр тооцдог. Энэ нь биеийн тамирын багш мэргэжлийн онцлог шаардлагыг хангасан суралцагч элсүүлэхэд дэмжлэг болдог байна.

- Гадаад оюутны элсэлтийн тоо

Биеийн тамирын сургууль нь 2018-2019 оны хичээлийн жилд БНХАУ-ийн ӨМӨЗО болсон МУБИС-ийн сургууль сурталчлах яармагт оролцон Багш, биеийн тамирын боловсрол хөтөлбөрөө сурталчилсан нь чухал үр дүнгээ өгч гадаад оюутан элсүүлэх эхлэл тавигджээ. Багш, биеийн тамирын боловсрол бакалаврын хөтөлбөрт 3 оюутан, докторантурын хөтөлбөрт 6 оюутан суралцуулж байна.

Анхаарах асуудал:

- Ирээдүйн олимп, тив, дэлхийн хэмжээний тамирчид бэлтгэх багш нарыг Багш, биеийн тамирын боловсрол хөтөлбөрт элсүүлэн суралцуулахын тулд шат дараалсан алхамуудыг авч хэрэгжүүлэхэд анхаарах. Үүнд сургуулийн үүсэн байгуулагдсан түүх, суралцаж төгссөн, төрөн гарсан спортын болон монголын алдартнууд, төр нийгмийн зүтгэлтнүүдийн талаарх мэдээллийг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх нь чухал юм.
- Хамтын ажиллагаатай гадаадын их, дээд сургуулиудтай хамтран ажиллах гэрээгээ өргөжүүлэн оюутан солилцоо, дүйцүүлэн суралцуулах хөтөлбөр зэргийг сурталчлах нь гадаад оюутны тоо өсөхөд чухал нөлөөтэй.

Зөвлөмж:

- Шинэ элсэгчдэд зориулсан сургууль сурталчлах арга хэмжээ, мэргэжлийн онцлогыг харуулсан контентуудыг видео хэлбэрээр монгол болон гадаад хэлээр гарган нийтэд түгээн дэлгэрүүлэх. Энэ нь тус хөтөлбөрөөр суралцах хүсэлтэй элсэгчдийн тоо болон дүйцүүлэх хөтөлбөрөөр суралцах оюутны тоог нэмэгдүүлэхэд нөлөөлнө.
- Гадаад улсын иргэнийг тус хөтөлбөрт элсүүлэн, дүйцүүлэн суралцуулахын тулд гадаадын олон оронтой хамтын ажиллагаагаа идэвхжүүлэх, мөн монгол оюутнуудыг гадаадын их дээд сургуульд суралцуулах, дүйцүүлэх 2+2 хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломжийг судлах нь тус хөтөлбөрөөр суралцах элсэгчдийн тоог нэмэгдүүлж болох юм.

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Зөвлөх, хөгжүүлэх үйлчилгээний төлөвлөгөө, тайлан
- Сэтгэл ханамжийн судалгаа, баримт материал
- Зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тайлан мэдээ.
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тайлан мэдээ

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Жил бүр хөтөлбөрийн алба, оюутны хөгжлийн албаны ажлын төлөвлөгөөнд оюутныг хөгжүүлэх, тэднийг дэмжин туслах чиглэлийн олон ажил төлөвлөн хэрэгжүүлдэг бөгөөд энэ ажлууд нь багш нарын жилийн ажлын төлөвлөгөөнд заавал тусгагддаг онцлогтой.
- МУБИС нь 2018 онд “Оюутны хөгжлийн хөтөлбөр (2019-2024)-ийг баталжээ. Энэ хөтөлбөр нь оюутны хөгжилд чиглэсэн олон талт үйл ажиллагааны зорилтуудыг тусгасан чухал ач холбогдолтой хөтөлбөр болжээ.
- 2018 оныг “Оюутны хөгжлийг дэмжих жил” болгон зарлаж сургуулийн хөтөлбөрийн алба, оюутны алба, оюутны зөвлөл, тэнхимтэй хамтран зохион байгуулахаар төлөвлөн сар бүр 1-2 ажлыг хэрэгжүүлжээ. Энэ нь оюутныг бие хүн болж төлөвших, багаар ажиллах чадвараа сайжруулах, спортын ур чадвар, зохион байгуулах ажилд суралцах сайхан боломжийг нээж өгдөг үр дүнтэй ажлууд болжээ.
- Багш, биеийн тамирын боловсрол хөтөлбөрт суралцагчид нь хичээл судлахаас гадна бие хүний төлөвшил, ёс зүй, зан төлөв, эрүүл аж төрөх ёс, бүл төлөвлөх, ёс зүй, харилцаа, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зэрэг хувь хүний төлөвшилд чиглэсэн ажлыг жилийн турш төлөвлөн хэрэгжүүлдэг. Жилд бие хүний төлөвшлийн сэдвээр уулзалт ярилцлага 1, харилцааны ёс зүй өдөрлөг 1, эрүүл мэндийн сургалт сурталчилгааны 3 ажил зохион байгуулжээ.

Багш, биеийн тамирын боловсрол хөтөлбөрөөр суралцагчдын дунд тодорхой сэдвээр жил бүр эрдэм шинжилгээний хурал зохион байгуулдаг.

Багш, биеийн тамирын боловсрол хөтөлбөрөөр суралцагч оюутны ЭШХ-д оролцсон байдал нэгтгэн үзвэл:

Хичээлийн жил	БТС-ийн ОЭШХ	МУБИС-ийн ОЭШХ	Улсын хэмжээний ОЭШХ		Олон улсын ОЭШХ	
			Оролцсон оюутны тоо	Байр эзэлсэн оюутны тоо	Оролцсон оюутны тоо	Байр эзэлсэн оюутны тоо
2014-2015	21	1	4	2	5	1
2015-2016	22	-	5	1	-	
2016-2017	20	2	4		-	
2017-2018	26	-	5	1	3	
2018-2019	24	2	4		-	
Нийт	105	5	22	4	3	1

Мөн оюутнуудад бусад бүрэлдэхүүн сургуулийн болон улсын хэмжээний их, дээд сургуулийн, олон улсын оюутны эрдэм шинжилгээний хуралд оролцох боломжийг бүрдүүлж өгчээ.

Анхаарах асуудал:

- БТС-ийн 2-р ангийн оюутнууд “Хөнгөн атлетикийн ур чадвар”-ын шалгалтыг ганцхан спортын төрөл, зөвхөн 2-р анги гэж хязгаарлахгүй спортын олон төрлөөс, анги тус бүрт тохирох, үзсэн хичээлээс нь сонгон ур чадварын шалгалтаа өргөжүүлэх хэрэгтэй. Спортын техникийн нэршил, зүй тогтолын тайлбарыг оюутанд сайн эзэмшүүлэх хэрэгтэй гэсэн саналыг ажил олгогчоос гаргаж байсныг анхаарах.
- Тус хөтөлбөрөөр суралцаж байгаа оюутанг СУДЛААЧ-БАГШ болгож бэлтгэхийн тулд сургуулийн хэмжээний эрдэм шинжилгээний хурлаас гадна эссэ бичлэг, мэтгэлцээн, хэлэлцүүлэг, фокус бүлгийн ярилцлага зэрэг ажлаар оюутны судлах, боловсруулах, илтгэх, чадварыг сайжруулах нь чухал юм.

Зөвлөмж:

- Ур чадварын шалгалтыг спортын төрөл бүрээр зохион байгуулах нь оюутны спортын олон төрлийн техникийг гүйцэтгэх чадвар сайжрах, үзүүлэх, тайлбарлах аргуудаа сайн эзэмших, спортын техникийн нэршил, зүй тогтолыг тайлбарлаж сурахад ач холбогдолтой.
- Эссэ, мэтгэлцээн, фокус бүлгийн ярилцлага, хэлэлцүүлэг, хуралд оролцохын тулд уншиж судалсан зүйлээ ургуулан бодох, задлан ялгах, сэтгэх, ярих чадваруудад оюутан бие дааж суралцана. Эдгээр ажлууд нь оюутны судалгаа шинжилгээний ажил хийх сэдэл, зорилго, идэвх, санаачилга, хүсэл тэмүүллийг нэмэгдүүлнэ.

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Оюутны клубийн зохион байгуулсан арга хэмжээ, тайлан мэдээ
- Суралцагчийн гүйцэтгэсэн сайн дурын ажлын үнэлгээ, урамшуулал
- Цагийн ажил, үндсэн ажилд зуучилсан төгсөгч, оюутны тоон мэдээлэл
- Олимпиад, уралдаан тэмцээнд оролцсон суралцагчийн тоо, үр дүнгийн мэдээлэл
- Урамшуулал, тэтгэлэг хөнгөлөлтөд хамрагдсан суралцагчдын тоо

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Биеийн тамирын сургуулийн дэргэд оюутны сайн дурын клубын үйл ажиллагаа одоогоор эхлэл шатандаа явж байна. Тус сургууль дээр оюутны “Төгс аялагч клуб” 2015 онд байгуулагдан 18 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа тогтмол явуулж иржээ. Энэ клубын оюутан чөлөөт цагаараа нийслэл хот орчмын түүхэн дурсгалт газруудаар,

амралтын үеэр эх орны үзэсгэлэнт байгальд аялах аяллыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулдаг.

- Мөн тодорхой клубын системтэй биш ч гэсэн оюутны спортын авьяасыг хөгжүүлэх спортын төрөл бүрийн дугуйлан хичээллэж оюутны спортын ур чадварыг дээшлүүлэх хичээл хэлбэрээр зохион байгуулж иржээ. Одоогоор 10 гаруй спортын төрлөөр эрэгтэй, эмэгтэй багаар болон ганцаарчилсан төрлийн сонгон суралцах хичээлд оюутнууд хамрагдан өндөр амжилтуудыг үзүүлжээ.
- Сургалтын төлөвлөгөөнд оюутны сайн дурын ажлын 2 кредитийг нэмж оруулсан нь сайн туршлага болж байна. Оюутны сайн дурын үйл ажиллагааны хүрээнд
 1. Жил бүр уламжлал болгон “ЭКО” аялал зохион байгуулж Тэрэлж чиглэлийн хог хаягдлыг цэвэрлэж, байгаль орчноо хамгаалдаг.
 2. “Онч” үгсийг сургуулийн хананд байршуулан оюутны төлөвшилд эерэгээр нөлөөлж орчноо танин мэдэх мэдлэг болдог
 3. Жил бүрийн хавар “Малчдад туслах аян” зохион байгуулдаг 2019 оны хавар 500 гаруй мянган төгрөгний эд материал цуглуулан хандивласан.
 4. Бүх оюутан сар бүр “Хөөстэй өдөрлөг” зохион байгуулж өөрийн сургуулийн үйлчилгээний ажилтнуудад туслан орчноо нөг өдөр цэвэрлэж өгдөг нь сайшаалтай.

Мөн сургуулийн хөтөлбөрийн албанаас

- ЕБС-ийн спортын секцэнд туслах багшаар ажиллах (суралцах хугацаанд туслах дасгалжуулагч хийж байсан 2018 оны оюутан одоо Шавь цогцолбор сургуульд ажиллахын зэрэгцээ волейболын дасгалжуулагч хийж байгаа)
- Олон улсын спортын тэмцээнд сайн дурын чиглүүлэгчээр (volenter) ажиллах зэрэг сайн дурын үйл ажиллагааг оюутанд санал болгожээ. 2018 онд Жижу-цу бөхийн Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнд 6 оюутан, Монголын хүүхдийн спортын V наадмын зохион байгуулалтад 20 оюутан, “Улаанбаатар марафон 2019”-д 14 оюутан сайн дурын ажилтнаар ажиллажээ.

Энэ ажлууд нь оюутныг сайн дурын ажил зохион байгуулах, туршлага хуримтлуулах, мэргэжлийн тал дээр өсөх, гадаад хэлний мэдлэгээ дээшлүүлэхээс гадна 2 кредитийн урамшуулал авдаг чухал ач холбогдолтой сайн туршлага болжээ.

- МУБИС оюутны хөдөлмөр эрхлэлтийн төв байгуулж 2017-2018 оноос үйл ажиллагаа нь эхэлсэн бөгөөд БТС-ийн оюутнуудаас 2017-2018 онд 26, 2018-2019 онд 27 нийт 53 оюутан тус төвөөр үйлчлүүлжээ. Энэ төв оюутны саналыг үндэслэн ажилд зуучилж өгдөг.
- Багш, биеийн тамирын боловсрол хөтөлбөрөөр суралцагч оюутнууд спортын уралдаан тэмцээнд тогтмол оролцож ирсэн. Жил бүрийн сургуулийн төсөвт спортын арга хэмжээ зохион байгуулах болон оролцоход шаардагдах зардалыг тусгаж өгдөг. Тэмцээнд оролцох оюутны тоглолтын хувцас, тэмцээний хэрэгслээр хангах ажлыг тэнхимийн саналыг үндэслэн зохион байгуулж байна. БТС-ийн оюутнууд тайлан хугацаанд улсын чанартай болон олон улсын, тив дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож иржээ. Жишээ нь: оюутнуудын тэмцээний амжилт медалийн тоогоор 6 жилийн хугацаанд
 - Улсын чанартай тэмцээнээс 446
 - Олон улсын тэмцээнээс 131
 - Тив, дэлхийн аваргаас 39 медаль хүртсэн амжилт үзүүлжээ.

Спортын болон олимпиад уралдаан тэмцээнд өндөр амжилт үзүүлсэн оюутныг МУБИС-ийн “Оюутны журам”-ын 7.14 заалтыг үндэслэн 1-4 кредитын тэтгэлэгт хамрагддаг. Одоогоор спортын өндөр амжилт үзүүлсэн 47 оюутан кредит тэтгэлэг авсан байна.

Анхаарах асуудал:

- Оюутны сайн дурын байгууллага болох клубын үйл ажиллагаа эхлэл төдий байгаа нь анхаарал татаж байна. Оюутны клуб байгуулах эрх зүйн орчин, нийгмийн орчин нь байхад

оюутнуудын идэвх санаачилга дутмаг, багш нарын чиглүүлэх үүрэг оролцоо хангалтгүй байгаа нь уулзалт, ярилцлагын үед анхаарал татаж байсан.

- МУБИС-ийн шилдэг оюутны урамшуулал, кредитийн тэтгэлэг зэрэгт хамрагдах маш олон оюутан хамрагдах боломж харагдаж байна. Ялангуяа кредитын урамшуулалд 616 оюутан хамрагдах болзол хангасан ч 47 оюутан хамрагдсан нь учир дутагдалтай байна. МУБИС-ийн “Оюутны журам”-ын тэтгэлэг хөтөлбөр, кредитийн тэтгэлэгтээ холбоотой мэдээллийг оюутанд цаг алдалгүй хүргэх шаардлагатай.

Зөвлөмж:

- Спортын олон төрлөөр сургуулийн шигшээ баг, сурах ур чадвараа дээшлүүлэх хичээл зохион байгуулагддаг. Энэ хичээлд тус хөтөлбөрөөр суралцаж байгаа оюутан бүр заавал хамрагддаг. Иймд тус хичээлийг спортын клуб хэлбэрээр зохион байгуулж үйл ажиллагааг нь өргөжүүлж болохоор харагдаж байсан. Жишээ нь сагсан бөмбөгийн клуб байгуулан тоглогч, шүүгч, дасгалжуулагч давхар бэлтгэн өсвөр нас, залуучууд, насанд хүрэгчдийн сургалт, хандивын тоглолт, үзүүлэх тоглолт гэх мэт үйл ажиллагаа явуулах боломжтой.
- Судлаач багш нараар удирдуулсан багш, оюутны хамтарсан эрдэм шинжилгээний клуб байгуулах боломжийг судалж, хэрэгжүүлэх. Энэ нь биеийн тамир, спортын салбарын шинэ залуу судлаачдын авьяасыг нээн илрүүлэх, судалгаан дээр үндэслэсэн баримт нотолгоог нийтэд түгээн дэлгэрүүлэхэд ихээхэн ач холбогдолтой ажил болно.

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

-Суралцагчийн шилжилт хөдөлгөөний судалгаа

-Багц цагийн дүйцэл, шилжилт хөдөлгөөний судалгаа, дүрэм журам

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУБИС-ийн “Сургалтын журам”-ын 4.11, 4.12 заалтыг үндэслэн хичээлийн жил бүр нийт оюутнуудын шилжилт хөдөлгөөний бүртгэл судалгааг явуулж, үр дүнг оюутны алба болон БСШУСЯ-д хүргүүлдэг. Өнгөрсөн таван жилийн хугацаанд
 - Эрүүл мэндийн шалтгаанаар 20, төрсөн жирэмсэн 6, ар гэрийн шалтгаантай 75, цэргийн албанд татагдсан 5, гадаадад суралцахаар 18 нийт 122 оюутан жил болон хагас жилийн чөлөө авсан.
 - Ар гэрийн шалтгаанаар 187, эрүүл мэндийн шалтгаанаар 6, сурах сонирхолгүй 1, гадаад явах 8, бусад их, дээд сургууль руу шилжих шалтгаанаар 64, нийт 263 оюутан сургуулиас гарсанаас 71.1% нь ар гэрийн шалтгаанаар сургуулиас гарчээ. Энэ нь сургалтын төлбөрийн чадвартай холбоотой юм.
- Тус сургуульд шилжиж ирсэн оюутан тухайн улирлын сургалтын төлбөрийг төлөхөөс бүрэлдэхүүн сургуулиас шилжин суралцагч нь сургалтын төлбөрийн 30%, гадны их дээд сургуулиас шилжиж ирэхэд 50%-тай тэнцэх төлбөрийг төлнө. Тайланд шилжилт хөдөлгөөний тухай баримт материалыг сүүлийн 5 жилээр гаргаж нэгтгэсэн байна.
 - Жилийн чөлөөнөөс 106 оюутан
 - МУБИС-ийн бүрэлдэхүүн сургуулиас 27 оюутан шилжин суралцахдаа сургалтын төлбөрийн 30% төлбөр
 - Бусад их, дээд сургуулиас 65 оюутан суралцахдаа сургалтын төлбөрийн 50%-тай тэнцэх төлбөр төлж шилжин суралцжээ.
 - Бусад их, дээд сургууль руу 28 оюутан буюу 23.2% байна. Энэ нь 2 төрлийн шалтгаанаас үүдэлтэй бөгөөд спортын тэмцээн, бэлтгэлд хамрагдаж олон сараар хичээлээс

чөлөөлөгдөх нь МУБИС-ийн кредитийг бүрэн биелүүлэхэд хүндрэлтэй байдагтай холбоотой. Зарим ижил төрлийн дээд сургуулиуд ЭЕШ-ын оноог харгалзахгүй сургалтын төлбөрийг 100% чөлөөлдөгтэй холбоотой байна.

- МУБИС-ийн бүрэлдэхүүн сургууль руу 13 оюутан шилжжээ.
- Оюутны өмнө нь судалсан хичээлийн кредитийг шилжүүлэн тооцох асуудлыг тухайн бүрэлдэхүүний сургуулийн хөтөлбөрийн албаны дарга, мэргэжлийн тэнхим, профессорын багийн ахлагч судлан тогтоож шийдвэрийг бүрэлдэхүүн сургуулийн захирал баталгаажуулах оюутныг дүрэм, журмын дагуу шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэж ирсэн. 2014-2019 оны хичээлийн жилүүдэд нийт 101 оюутанд 1500 кредитийн хичээлийг дүрмийн дагуу дүйцүүлэн тооцож, шилжилт хөдөлгөөнийг оюутны эрх ашигт нийцүүлэн шуурхай шийдвэрлэжээ.

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

Төгсөлтийн баримт бичгийн загвар

-Төгсөлтийн баримт бичгийг олгох дүрэм журмын хэрэгжилтийн байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөгчдөд олгодог диплом нь 2014-2016 онд Монгол – Англи хэлээр, 2017 оноос Монгол – Англи - Уйгаржин бичгээр хэвлэн гаргасан хавсралт бүхий МУБИС-ийн тэмдгээр баталгаажих тэмдэг, бүртгэлийн дугаартай байдаг. Төгсөгчийн мэдээлэл, дипломын дугаар нь БСШУСЯ болон боловсролын төрийн сангийн нэгдсэн санд бүртгэгдэх бөгөөд төгсөгчийн бичиг баримт, мэдээллийг цахим хэлбэрээр шалгах боломж бүрдүүлдэг.
- “Багш, биеийн тамирын боловсрол” хөтөлбөрийн заавал болон сонгон судлах хичээлүүдийг амжилттай судалж, 120-оос доошгүй кредит цуглуулсан, ахицын шалгалтаар хангалттай үнэлгээ авсан, 1.7-оос доошгүй голч оноотой суралцагчид МУБИС-ийн бакалаврын зэрэг олгодог. Төгсөлтийн салбар комиссын шийдвэрийг үндэслэн, МУБИС-ийн захиралын тушаалаар төгсгөн, мэргэжил, боловсролын зэрэг, түүнийг гэрчлэх төгсөлтийн баримт бичиг болох диплом, энгэрийн тэмдэг олгодог. Хөтөлбөрийн албаны дарга тухайн нэг оюутны бакалаврын зэрэг авахад заавал судлах хичээлүүдтэй холбоотой асуудлыг шийдвэрлэдэг. МУБИС-ийг 3.7 буюу түүнээс дээш голч дүнтэй төгссөн бакалавр зэргийн суралцагч нь
 - магистрын сургалтад элсэлтийн шалгалтгүйгээр элсэх давуу эрхтэй.
 - магистрын сургалтын тухайн жилийн төлбөрөөс 15 хувийн хөнгөлөлт эдэлдэг байна.

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилгоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

-Хөтөлбөрийн хүний нөөцийн цогц бодлогын баримт бичиг, хэрэгжилтийн тайлан

-Доктор зэрэгтэй багш нарын эзлэх хувийн жин, судалгаа /сүүлийн 5 жилээр/

-Багш, суралцагчдын тооны зохистой харьцааны судалгаа /сүүлийн 5 жилээр/

- Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагад нийцсэн байдлын судалгаа.
- Багшийн цагийн ачаалал тооцсон судалгаа
- Багш нарт олгосон урамшууллын судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багш, биеийн тамирын боловсрол болон бусад хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хүний нөөцийн чадварлаг багш, ажилтан шалгаруулахдаа МУБИС-ийн Захирлын 2015 оны А/172 тоот тушаал, 2018 оны А/344 тоот захиралын тушаалаар 32 заалтыг шинэчлэн найруулан баталсан “Багшийн ажиллах журам”-ыг баримталдаг. Багш сонгон шалгаруулах асуудал нь МУБИС-ийн Багшийн ажиллах журмын 3.1 зүйл болон сургуулийн дотоод журмаар зохицуулагддаг. МУБИС-д багш сонгон шалгаруулах дүрэм, журмыг 2007, 2015 онд шинэчлэн боловсруулсан байна. Шалгалтад тэнцсэн багшийг ажилд авах эсэхийг Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ гэсэн заалтыг үндэс болгон 2015 онд 2, 2016 онд 1 багш ажилд шинээр авчээ.
- Биеийн тамирын сургууль дараах бүрэлдэхүүнтэйгээр сургалт хүмүүжлийн үндсэн үйл ажиллагааг профессор 1, дэд профессор 4, ахлах багш 9, багш 16, гэрээт багш 1, хичээлийн туслах ажилтан 2, хөтөлбөрийн мэргэжилтэн 2, оюутан хариуцсан мэргэжилтэн 1 явуулж ирсэн. Мөн сургуулийн онцлогтой холбоотойгоор мэргэжлийн ур чадвар сайтай багш сонгон шалгаруулж авдаг. Тухайлбал: спортын гавъяат дасгалжуулагч 1, олон улсын хэмжээний мастер 6, спортын мастер 9, спортын дэд мастер 1, хүний их эмч 2, спортын эмч 1 багш ажиллаж байна.
- Биеийн тамирын сургууль докторын зэрэгтэй багш нарын эзлэх хувийн жин жил бүр нэмэгдэж, 2018-2019 оны хичээлийн жилд нийт багш нарын 41.3% эрдмийн зэрэгтэй байсан бол 2019-2020 оны хичээлийн жилд 46.6% болон өссөн нь МУБИС-ийн хөгжлийн бодлогод 2019 онд доктор зэрэгтэй багш нарын эзлэх хувийг 45%-д хүргэнэ гэсэн зорилтыг биелүүлсэн онцлох үйл явдал болсон байна.
- Нэг багшид ноогдох оюутны тооны харьцаа байнга өөрчлөгдөж байдаг. Тухайлбал оюутнуудын шилжилт хөдөлгөөн, жилийн чөлөө авах, багш нарын 1-2 жилийн хугацаатай гадаадын их, дээд сургуульд мэргэжил дээшлүүлэн сургалтад хамрагдах, БТС-ийн багш нарын эрдэмжилт өсөн нэмэгдэж профессор багш нарын кредит цагийг тооцох журамд өөрчлөлт орсон байна. Тайлант хугацаанд 2014-2015 онд 1:18, 2018-2019 онд 1:23, “Багш, биеийн тамирын боловсрол” хөтөлбөрийг хэрэгжүүлдэг нэг багшид дунджаар 20 оюутан ноогддог нь багш, суралцагчийн тооны харьцаа зохистой түвшинд байна.
- МУБИС-ийн Багшийн албан тушаалын зэрэглэл тогтоох удирдамж, шалгуур үзүүлэлтийг 2018 оны 03-р сарын 15-ны А/73 тоот захирлын тушаалаар баталсан ба 2019 оны 04-р сарын 18-ны А/113 тоот тушаалаар шинэчлэн найруулжээ. Энэхүү шалгуур үзүүлэлтийг хангаж БТС-ийн багш нараас 2014-2015 онд 2 багш ахлах багш, 2016-2017 онд 1 багш профессор, 2017-2018 онд 4 багш дэд профессор зэрэглэлд ажиллах болжээ. Мөн 2 багш доктор зэрэг хамгаалсан боловч албан тушаалын зэрэглэл ахиулаагүй байна.
- Багш нарын нийгмийн асуудлыг дараах байдлаар хөнгөлөлт үзүүлж, дэмжиж ажилладаг байна.
 - МУБИС-ийн докторын сургалтын төлбөрөө 50% -ийн хөнгөлөлт эдэлсэн 13 багш
 - Олон улсын чансаа өндөртэй сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэхэд санхүүгийн дэмждэг
 - Сарын бага хүүтэй орон сууцны зээлд хамрагдсан – 3 багш
 - МУБИС-ийн харьяа Лицей сургууль, цэцэрлэгт 10%-ийн хөнгөлөлттэй сургах – 4 хүүхэд
 - Ар Гүнтэд зуслангийн газар, байртай болсон – 6 багш байна.
- Багшийн ажиллах журмыг үндэслэн БТС-ийн захирлын тушаалаар улирлаар тооцон цалин, урамшуулал дээр 3-5%-ийн үр дүнгийн нэмэгдэл, спортын зэрэг цолны 3-4%-ийн нэмэгдэл олгодог. Багш нартай ярилцах үед доктор хамгаалсан багшид нэг удаа 300 000 мянган төгрөгний мөнгөн урамшуулал олгодог талаар дурдсан.

- МУБИС-ийн оюутнуудыг бэлтгэн олон улс, тив дэлхийн хэмжээнд амжилттай оролцон эхний байрт шалгарсан багшид 2 хүртэлх кредитийн мөнгөн урамшуулал МУБИС-ийн захиралын нэрэмжит шагнал олгох 5.4.9 заалтыг үндэс болгон 2019 оны хичээлийн жилд 2 багш урамшуулал авсан. Мөн багш нарын сургалт, дасгалжуулалт, эрдэм шинжилгээний ажлын үзүүлэлтийг үнэлэн сургуулийн “Шилдэг дасгалжуулагч”, “Шилдэг заах арга зүйч”, “Шилдэг судлаач” багшийг сүүлийн шалгаруулдаг сайн туршлага болжээ.

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

-Багшлахуйн ур чадвар, судалгааны ур чадвар, суралцах хэрэгцээг тодорхойлсон судалгаа, судалгааны дагуу хийсэн ажлын баримт

-Төлөвлөгөө, тайлан

-Багшийг гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлж чадавхжуулсан судалгаа.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- БСШУС-ын сайдын тушаалаар 2018 онд “Багшийн хөгжлийн хөтөлбөр”-ийг баталсан. Энэ хөтөлбөрийн хүрээнд МУБИС 2018 оны 10-р сарын 10-ны А/249 тоот захирлын тушаалаар 2019-2024 он хүртэлх “Багшийн хөгжлийн хөтөлбөр”-ийг баталсан. Энэ хөтөлбөрийн дагуу багш нарын эрдэм шинжилгээний ажилд ахиц гарч 2 багш доктор хамгаалж, 7 багш албан тушаалын зэрэглэл ахиулсан.
- Багш нараа мэргэжлийн мэдлэг, чадварыг хөгжүүлэхийн Монгол улсын “Багшийн хөгжлийн тухай хууль”, МУБИС-ийн “Хөгжлийн бодлого”, “Багшийн хөгжлийн хөтөлбөр”-г тулгуурлан үе шаттай төлөвлөн хэрэгжүүлж ажилладаг. Тайлант хугацаанд жил бүр багш нар оюутны мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх чиглэлээр улсын болон олон улсын тэмцээн уралдаанд 4 удаа нийт багш нарын 58% нь оюутныг удирдан, өөрийн мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэхэд 4 удаа нийт багш нарын 42% оролцсон байна.
- **Мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан багш нарын тоо (давхардсан тоогоор)**

№	Хичээлийн жил	Дотоодод	Гадаадад
1	2014-2015	13 сургалт 31 багш	6
2	2015-2016	10 сургалт 11 багш	2
3	2016-2017	12 сургалт 31 багш	2
4	2017-2018	8 сургалт 33 багш	4
5	2018-2019	8 сургалт 100 багш	9
Нийт		210	23

- Тайлант хугацаанд дотоодод нийт 51 сургалтад 100 багш, гадаадад докторантур, магистр, 45 хоногийн сургалтад нийт 23 багш мэргэжлээ дээшлүүлжээ.

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Боловсролын болон шинжлэх ухааны шинэ туршилт, инновац, ашигтай загвар, патентийн тоон судалгаа
- Бодлогын баримт бичиг, дүрэм журам
- Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, судалгааны ажлын тайлан мэдээ, хөтөлбөрт тусгагдсан байдал
- Нийтлэгдсэн бүтээл, судалгааны ажил, эшлэгдсэн тоо

- Зарцуулсан төсөв, тайлан

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг чанаржуулах нийтэд таниулах үүднээс олон талт арга хэмжээ авч, эрдэм шинжилгээ судалгааны ажлын тэргүүлэх болон суурь, хавсарга судалгааны чиглэлийг тодорхойлсон нь сайн туршлага болж байна. Үүний үр дүнд багш нар:
 - Д.Баярлах ахлах ангийн биеийн тамирын сургалтын хэрэглэгдэхүүн, Г.Энхсайхан ахлах тусгай хэрэгцээт хүүхдийн бие бялдрыг хөгжүүлэхэд зориулсан хэрэглэгдэхүүнийг МУБИС-ийн инновацийн төслөөр хийж сургалтад ашиглаж байна.
 - 2018 онд Профессор Л.Уртнасан ахлан “Багш, биеийн тамирын боловсрол”-ын хөтөлбөрт зориулан гаргасан “Хөнгөн атлетик” сурах бичигтээ зохиогчийн эрхийн ГЭРЧИЛГЭЭ авсан байна.
- Багш нар гэрээгээр ЕБС-ийн багшийн ном 10, сургалтын цөм хөтөлбөр 4, суралцахуйн удирдамж, зөвлөмж боловсруулахад 10 багш давхардсан тоогоор 30 удаа гэрээгээр ажиллажээ.
- **БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН БОЛОВСРОЛ**” мэргэжлийн хянагддаг эрдэм шинжилгээний сэтгүүлтэй болсон.
- Улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурал зохион байгуулдаг болсон. Сургуулийн хэмжээний эрдэм шинжилгээний хурал уламжлал болсон.
- Багш нарын төсөлт ажилд оролцох оролцоо нэмэгдэж тайлант хугацаанд давхардсан тоогоор 77 багш Үндэсний хэмжээний 12 төсөл, МУБИС-ийн 10 төсөл, Гадаадын санхүүжилттэй 7 төсөл хэрэгжүүлж ажиллажээ.
- Эрдэм шинжилгээний бүтээлээ хэвлэн нийтлүүлсэн гадаадын тоо үзүүлэлт 1-5, дотоодынх 10-51 болж ОХУ-д 3, Казакстанд 5 өгүүлэлээ хэвлүүлж, Туркменистанд 1 багш илтгэлээ хэлэлцүүлсэн байна. “Теория и практика физической культуры” сэтгүүлд И.Жамьяандагва, Д.Баярлах нар “Три игры мужей и физическое образование” өгүүлэлээ хэвлүүлсэн.
- Тайлант хугацаанд эрдэм шинжилгээний ажилд зарцуулах төсвийн 14.1%-ийг дотоодын төсөл хөтөлбөрт, 72.3%-ийг эрдэм шинжилгээний ажилд, 13.8%-ийг төсөл хөтөлбөрт зарцуулжээ. Гэхдээ 2014 онд дотоодын төсөл хөтөлбөрт, 2016, 2017, 2019 онд эрдэм шинжилгээний ажилд хамгийн төсөв зарцуулжээ.

Анхаарах асуудал:

- Боловсролын болон шинжлэх ухааны туршилт одоогоор хийгдэж эхлээгүй байна.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нар гадаадын болон дотоодын судлаачидтай хамтран судалгааны ажил хийж, үр дүнг өндөр индекстэй мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлэх

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- Багшийн өөрийн үнэлгээний тайланг үнэлэх дүгнэх журам, хэрэгжилтийн тайлан
- Багшийн өөрийн үнэлгээний тайлан
- Хөндлөнгийн үнэлгээний дүн
- Багшийн үнэлгээний дагуу авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний тайлан мэдээ
- Багшийн хавтас

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Биеийн тамирын сургуулийн Хөтөлбөрийн алба, Оюутанд үйлчлэх алба, тэнхим, профессор багш бүр МУБИС-ийн “Хөгжлийн бодлого”, “Багш хөгжлийн хөтөлбөр”, тэнхим, алба нэгжийн хөгжлийн стартеги төлөвлөгөөн дээр тулгуурлан, өөрсдийн ажлаа өмнөх хичээлийн жилийн эцэст хэлэлцэн, ирэх хичээлийн жилийн төлөвлөгөөг төлөвлөж, тэнхимийн, БТС-ийн, МУБИС-ийн хичээлийн жилийн төлөвлөгөөг боловсруулдаг онцлогтой.
- Багш нар төлөвлөснөө хэрхэн биелүүлсэн тухай тайлангаа улиралын төгсгөлд, хичээлийн жилийн эцэст, гурван жилд нэг удаа өөрийн үнэлгээний тайланг бичиж ажлаа дүгнүүлдэг. Багшийн өөрийн үнэлгээний тайлангаа сургалтын талаар (А), эрдэм шинжилгээ судалгааны ажлын талаар (В), бүтээлч ажлын талаар (С) бусад гэсэн чиглэлээр тайлангаа бичиж, тэнхимийн хамт олондоо хэлэлцүүлж цаашид хийх ажлаа төлөвлөдөг.
- 2019 оны 4-р сард МУБИС-ийн “Хөгжлийн хөтөлбөрийн бодлого”-ын хэрэгжилтэд захирлын тушаалаар комисс гарган багш нарын 2015-2018 оны 3 жилийн ажлыг үнэлэхэд БТС-ийн багш нар хангалттай сайн үнэлгээ авсан.
Сургуулийн захирал 3 жилийн ажлын тайлан түүний биелэлтэд хяналт тавьж, дараагийн 3 жилийн төлөвлөгөөг багш нэг бүрээр гаргуулан хөдөлмөрийн гэрээг сунгасан байна.
- Багшийн вэб хуудас буюу хавтас нь багшийн ерөнхий мэдээлэл, багшийн баримт бичиг, багшийг сонгосон зөвлөх оюутнуудтай холбоотой мэдээллүүдийг багтаасан байна.
 - Оюутны хичээлийн ирц, хичээлийн цагийн тооцоо
 - Зөвлөх ангийн оюутнуудтай захиагаар харилцах
 - Заасан хичээлийн дүнгийн тархалт
 - Улирлын төгсгөлд оюутнаас улирал бүр багшийн заасан хичээл, арга зүйн талаар 11 асуулттай сэтгэл ханамжийн онлайн судалгаа авч үр дүнг боловсруулан багш нарт илгээдэг. Энэхүү судалгааны дундаж дүн 90% байгаа нь багш нарын заах арга, ур чадвар, мэргэжил мэдлэгээ эзэмшсэн болон оюутанд мэдлэг түгээх чадвар сайн оюутны сэтгэл ханамж хангалттай өндөр байгаа нь харагдаж байна.
 - МУБИС-ийн дүрэм, журам, тогтоол шийдвэрүүдтэй танилцах боломжтой.

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажуулалт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн чанарын дотоод баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын удирдлага, зохион байгуулалтын схем
- Чанарын дотоод баталгаажуулалтын тогтсон бодлого, журам, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, үнэлгээ
- Чанарын дотоод баталгаажуулалтад хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангах чиглэлээр хийсэн ажлын тайлан мэдээ

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын тогтолцоо нь хөтөлбөрийн боловсруулалт, хөтөлбөрийн хэрэгжилт гэсэн үндсэн хоёр хэсгээр оролцогчдын сэтгэл ханамж, мөн хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгээр үнэлдэг. Энэ үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах нэгж нь Чанарын баталгаажилт, хяналт үнэлэгээний алба” болон “Сургалтын хөтөлбөр, багшийн хөгжлийн алба” юм.

- МУБИС-ийн захирлын 2015 оны А/265 тоот тушаалаар “МУБИС-ийн дотоод журам”-д зааснаар хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт болон сургалтын хөтөлбөрийн чанарыг үнэлдэг байна. 2017-2018 оноос “Хичээлийн үнэлгээний удирдамж”, МУБИС-ийн Хөтөлбөрийн хорооны ажиллах журам”, “Үнэлгээний даалгавар боловсруулах шаардлага, зөвлөмж”-ийг тус тус боловсруулан хэрэгжүүлж байна.
- Сургалтын хөтөлбөрийн боловсруулалт, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, хичээлийн хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх судалгааг оюутан, багш, төгсөгч оюутан, ажил олгогч нараас авсан судалгааны үр дүнд үндэслэн МУБИС-ийн журамд:
 - Оюутны журмын 20 заалтыг сайжруулж, 2 заалт шинээр нэмж, 1 заалтыг хасах
 - Багшийн ажиллах журмын 17 заалтыг сайжруулж, 19 заалт шинээр нэмж, 6 заалтыг хасах
 - Сургалтын журмын 79 заалтыг сайжруулж, 8 заалт шинээр нэмж, 15 заалтыг хасах өөрчлөлт оруулсан байна.
- “Багш, биеийн тамирын боловсрол” хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ ЕБС-ийн удирдлага, биеийн тамирын багш нар, аймаг, нийслэлийн боловсролын газар, БМДИ, Биеийн тамир, спортын газар зэрэг хөтөлбөрийг сонирхогч талуудтай хамтран ажиллаж иржээ. Эдгээр оролцогч талуудаас сэтгэл ханамжийн судалгаа авч гарсан үр дүнд дүн шинжилгээ хийж сул талыг тодруулах, хөтөлбөрийг сайжруулах талын санал авах үйл ажиллагааг анхааран ажилласан байна.

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

Илрэл нотолгоо:

- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа, дүгнэлт, үр дүн
- Төгсөгчдийн карьер өсөлтийн судалгаа, дүгнэлт, үр дүн
- Төгсөгчдийн ажлын байраар хангагдах хүртэлх хүлээх хугацааны судалгаа, дүн шинжилгээ
- Оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгаа, дүн шинжилгээ /Ажил олгогч, мэргэжлийн холбоод, төгсөгч гэх мэт/
- Хөтөлбөрийн үр дүнгийн судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөгчдийн ажил эрхлэлтийг сүүлийн 5 жилийн судалгаанаас харахад 20-45% нь ЕБС-д, 1.6-3% нь их, дээд сургуульд, 1.6-9% нь цэцэрлэгт биеийн тамирын багш, 2.7-8.6% нь үндэсний шигшээ багт тамирчин, 4.6-9% нь биеийн тамирын арга зүйч, 4.8-8.1% нь дасгалжуулагчаар ажиллаж байна. Уг хөтөлбөрөөр төгсөгчдийн карьер өсөлтийн судалгаа, ажлын байраар хангагдах хүртэлх хүлээх хугацааны судалгаа, дүн шинжилгээ судалж өөрийн үнэлгээний тайланд тусгаагүй байсан. Гэхдээ ажил олгогч нартай хийсэн ярилцлага дээр төгсөгчдийн хувь хүний карьер өсөлттэй холбоотой мэргэжил мэдлэгээ дээшлүүлэх хүсэл эрмэлзэл, ажилд хандах хандлага, ирээдүйн боломжуудаа үнэлэх чадвар, цаашид мэргэжил, албан тушаалын хувьд өсөх мэдлэг, чадвар, боломж байгаа талаар тодруулахад МАШ САЙН гэж үнэлж байжээ.
- “Багш, биеийн тамирын боловсрол” хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ ЕБС-ийн удирдлага, биеийн тамирын багш нар, аймаг, нийслэлийн боловсролын газар, БМДИ, БТСГ зэрэг хөтөлбөрийн сонирхогч талуудтай хамтран ажиллаж иржээ. 2017-2018 оны хичээлийн жилд авсан судалгааны зарим үр дүнгийн дундаж үнэлгээ дурдвал:
 - биеийн тамирын багш нар сургалтын хөтөлбөрийг дундаж 81%,
 - эрдэм шинжилгээний ажлын үнэлгээний дундаж 75%
 - боловсролын чанарын үнэлгээний дундаж 80% гэж үнэлсэн байна.

Оюутнуудаас авсан үнэлгээний дунджийг 2 үзүүлэлтээс харвал:

- сургалтын хөтөлбөрийн үнэлгээний дундаж 79%
- сургалтын орчныг 80%
- мэргэжлийн багш нарын мэргэжлийн ёс зүйг 91% гэж үнэлсэн байна.
- Биеийн тамирын сургуулийн хөтөлбөрийн дэд хороо “Багш, биеийн тамирын боловсрол хөтөлбөр”-ийг сайжруулах, чанаржуулах талаар:
 - Хичээлийн жилд 3-4 удаа хуралдаж, хөтөлбөрийн асуудлыг хэлэлцсэн
 - Хөтөлбөр боловсруулалт, сайжруулалттай холбоотой сургалтыг олон удаа зохион байгуулсан
 - 2015 онд Монголын үндэсний бөхийн холбоотой “Үндэсний бөх”-ийн спортыг ЕБС-д хөгжүүлэх арга зүйн хэлэлцүүлэг хийсэн.
 - 2017 онд Монголын хөл бөмбөгийн холбооны мэргэжлийн дасгалжуулагч нараар “Багш, биеийн тамирын боловсрол” хөтөлбөрийн “Хөл бөмбөг-1”, “Хөл бөмбөг-2” хичээлийн хөтөлбөрийг уншуулж санал авчээ.
 - Монголын хөл бөмбөгийн холбооноос “Хөнгөн атлетик” сурах бичиг болон “Хөнгөн атлетик I, II” хичээлийн хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээ дүгнэлт хийлгэжээ.
 - 2018-2019 оны хичээлийн жилд 2 тэнхимийн 4 багшийн хичээлд тус бүр 1 удаа тэнхимээс хөндлөнгийн үнэлгээ хийхэд дундажаар 56-64%-тай үр дүн тааруухан дүгнэгдсэн. Иймд хөтөлбөр хэрэгжилтийн 30 кредит тутамд ахицын үнэлгээ хийж үр дүнг тооцох ажлыг хэрэгжүүлж эхэлжээ.

Анхаарах асуудал:

- Төгсөгчдийн ажил хүлээлтийн хугацааны судалгаа, төгсөгчийн карьер өсөлтийн судалгааг хийх шаардлагатай.
- Оролцогч талуудаас /ажил олгогч, мэргэжлийн холбоод, төгсөгч/ хөтөлбөртэй холбоотой, цаашид сайжруулах сэтгэл ханамжийн судалгаа авч дүн шинжилгээг өөрийн үнэлгээний тайланд тусгах

Зөвлөмж:

- Төгсөгчдийн ажил хүлээлтийн судалгаа болон эрхэлж байгаа ажлын байрны судалгааг гаргах нь энэ хөтөлбөрөөр төгсөгчдийн эрэлт хэрэгцээг тодорхойлох, хөрвөх боломж байгаа эсэхийг тодруулан хөтөлбөрийг өргөжүүлэх.

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

-Магадлан итгэмжлэх байгууллагаас гаргасан дүгнэлт, зөвлөмж, шаардлага, магадлан итгэмжилсэн шийдвэр

-Хөтөлбөрөөр төгсөгчдийг мэргэжлийн салбарт хүлээн зөвшөөрснийг нотлох баримт бичгийн судалгаа, /мэргэжлийн зэрэг, эрхийн үнэмлэх гэх мэт/

-Мэргэжлийн холбоодтой хамтран ажилласан ажлын тайлан мэдээ.

-Дотоод, гадаадын дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж буй төгсөгчдийн хувь

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- “Багш, биеийн тамирын боловсрол” хөтөлбөр нь үндэсний болон олон улсын хэмжээнд магадлан итгэмжлүүлж байгаагүй.
- Сургуулийн түүхт 65 жилийн хугацаанд хөдөлмөрийн баатар 3, ардын багш 7, гавъяат багш 5, гавъяат дасгалжуулагч 32, гавъяат тамирчин 43, спортын гавъяат багш 3, шинжлэх ухааны доктор 2, боловсролын доктор дэд профессор 37 төрөн гарсан байна.

- 2015 онд Монголын үндэсний бөхийн холбоотой “Үндэсний бөх”-ийн спортыг ЕБС-д хөгжүүлэх арга зүйн хэлэлцүүлэг хийсэн. 2017 онд Монголын хөл бөмбөгийн холбооны мэргэжлийн дасгалжуулагч нараар “Багш, биеийн тамирын боловсрол” хөтөлбөрийн “Хөл бөмбөг-1”, “Хөл бөмбөг-2” хичээлийн хөтөлбөрийг уншуулж санал авчээ.
- Монголын хөл бөмбөгийн холбооноос “Хөнгөн атлетик” сурах бичиг болон “Хөнгөн атлетик I, II” хичээлийн хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээ дүгнэлт хийлгэжээ. Дараагийн шатны хөтөлбөрт төгсөгчдийн 1.6-2.6% нь, гадаадад 1.8-6.1% нь мэргэжлээрээ суралцаж байна.

Анхаарах асуудал:

- Багш хүн судлаач байх ёстой тиймээс төгсөгчдийг дараагийн шатны хөтөлбөрт хамрагдах боломжоор хангах, удирдан чиглүүлэх талаар олон хувилбартай төлөвлөгөө боловсруулахад анхаарах

7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

ДҮГНЭЛТ

Биеийн тамирын сургалтын онол, арга зүйн чиг хандлагыг тодорхойлох үйл ажиллагааг идэвхтэй олон жилийн турш хэрэгжүүлж, сургалтын олон хэлбэрээр гадаадын их, дээд сургуулиудтай хамтран ажиллаж ирсэн. Багшлах боловсон хүчин сайн бэлтгэгдсэн ба нийт багшаас эрдмийн зэрэгтэй 14 багш буюу 46.3%-ийг эзэлдэг. Мөн багш нар спортын ур чадвартай, спортын дэд мастераас дээш зэрэг, цолтой.

Төгсөгчид ажлын байран дээр өсөх, мэргэжлээ дээшлүүлэх чадвартай, бие хүний хувьд төлөвшсөн, ажлын ачаалал даах чадвартай, мэргэжлээ хөрвүүлэн ажиллах чадамжтай байдаг. Оюутнуудын оролцоог чухалчилдаг, хөтөлбөрийн хамтран оролцогч талуудаас сэтгэл ханамжийн судалгааг байнга авч үр дүнд нь тулгуурлан сургалтын орчин, материаллаг бааз, үйл ажиллагаагаа тогтмол сайжруулдаг.

Оюутнуудын суралцах таатай орчин нөхцөлийг бүрдүүлсний зэрэгцээ сургалтын тэтгэлэг, хөнгөлөлт, тусламжид хамрагдахад байнга тусалж ажилладаг.

Түүхэн хугацаандаа шинжлэх ухаан, олон улс, тив дэлхий олимпид гаргасан спортын өндөр амжилтууд, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнгүүд тус хөтөлбөрт тусгагдсан.

Шалгуур	Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан /х/х, хангаагүй дэд шалгуур байвал үндэслэлийг тодорхой бичнэ./
1 Хөтөлбөрийн төлөвлөлт	+			
2 Сургалтын үйл ажиллагаа	+			
3 Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	+			
4 Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	+			4.5 хэсэгчлэн хангасан
5 Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	+			
6 Багшийн үйл ажиллагаа	+			
7 Чанарын үнэлгээ, баталгаажилт	+			7.2 хэсэгчлэн хангасан
Дүгнэлт	Бүрэн хангасан			

НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ

Шалгуур	Зөвлөмж
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> Ажил олгогчдын эрэлт, хүсэлтийг хөтөлбөрт тусгах талаар байнгын судалгаа хийж, боломжит өөрчлөлтийг цаг алдалгүй хийж байх;
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> Хөтөлбөрийн суралцахуйн зорилгот үр дүнг мэргэжлийн хичээлүүдээс гадна ерөнхий суурь хичээлүүдийн хөтөлбөртэй нягт уялдуулж, агуулгыг холбон баяжуулахад анхаарах;
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	<ul style="list-style-type: none"> Суралцагчдын бие даан суралцах орчинг сайжруулах Мэргэжлийн шинэ ном сурах бичиг, бүтээлийн тоог нэмэгдүүлэх, мэргэжлийн тэнхимийн багш нар хамтран сурах бичиг зохиох тал дээр анхаарч ажиллах
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> Ижил хөтөлбөрөөр мэргэжилтэн бэлтгэдэг дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагуудын эрдэмтэн судлаач, багш нартай хамтарсан төсөл, хөтөлбөр, судалгаа шинжилгээний ажлыг нэмэгдүүлэх.
Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	
Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нар гадаадын болон дотоодын судлаачидтай хамтран судалгааны ажил хийж, үр дүнг өндөр индекстэй мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлэх
Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт	<ul style="list-style-type: none"> Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааг идэвхжүүлэн хөтөлбөрийн өөрчлөлт, агуулгын шинэчлэлд тэдний саналыг тусгахад анхаарах; Төгсөгчдийг давтан сургах замаар төгсөгчдийн оролцоог хөтөлбөрийн үйл ажиллагаа руу татан оролцуулах;

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг МУБИС-ийн Биеийн тамирын сургуулийн “Багш, биеийн тамирын боловсрол” бакалаврын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг БМИҮЗ-ийн БОЛОВСРОЛ-ын чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэгП.Лхагвасүрэн

Гишүүд:Р.Гантулга

.....Ч.Зоригтбаатар

IV. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал
/албан бичгийг оруулах/



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛЬ
БИЕЙН ТАМИРЫН СУРГУУЛЬ

14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Бага тойруу 14, Утас/Факс: (976-11) 32 18 70,
E-mail: spe@msue.edu.mn, http://www.msue.mn

2020.06.04 № 43
танай _____-ны № _____-т

БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛД

Биеийн тамирын сургууль нь БМИУЗ-ийн шинжээчдийн зөвлөмжийг хүлээн авч шалгуур тус бүрийг зөвлөмжийн дагуу засч сайжруулж байна.

ЗАХИРАЛ



Г.ЭНХСАЙХАН